

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.06.28.

Арвайхээр сум

Тус цагдаагийн газрын алба хаагчид нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2023 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав.

### **Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, Хууль зүй дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн үүрэг ажлын чиглэл, дэд дарга нарын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 46 ажил, арга хэмжээг төлөвлөн Цагдаагийн ерөнхий газрын даргаар баталгаажуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг 80.2 хуваарь дүгнэж ажилласан.

Тус цагдаагийн газраас Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор цагдаагийн газрын хэлтэс, тасаг, алба хаагч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулан, энэ оны эхний хагас жилийн байдлаар дүгнэж ажиллав.

Тус газарт 2023 оны эхний хагас жилийн байдлаар сүлжээгээр 2313, бусад газраас 217 нийт 2530 албан бичиг ирснийг бүртгэлд авч, хариуцсан алба хаагч нарт цохолтоор хүргүүлэн, цагдаагийн газраас 2892 албан бичгийг холбогдох байгууллага албан тушаалтан, иргэнд хүргүүлэн, 33 тусгай шууданг хүлээн авч, 27 тусгай шууданг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлэн ажилласан байна.

Цагдаагийн газрын даргаас үйл ажиллагаатай холбоотой 41, боловсон хүчний 112, нийт 153 тушаал батлагдаж, тушаалын хэрэгжилтэд улирал бүр үнэлэлт өгч, дүнг цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцон ажилласан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 23 алба хаагчид томилолт олгож ажилласан байна.

**Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан төлөвлөж ээлжит 7, ээлжит бус 1 нийт 8 удаагийн зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөг гарган батлуулж 8 удаагийн хуралд 82 асуудал хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Хэлэлцсэн асуудлыг ангилж үзвэл: албаны шалгалт 7, тасаг албадын сарын ажлыг дүгнэх 1, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 2, хүний нөөцийн чиглэлээр 48, тэтгэмж 4, тэтгэвэр 1, цол 1, шагнал 2, бусад 16 асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан байна.

**Хүний нөөцийн талаар:** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн А/293 дугаар тушаалаар офицер 109, ахлагч 82, гэрээт 4,

энгийн 5, нийт 200 алба хаагч, ажилтны орон тоотой батлагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор зарлагдсан сонгон шалгаруулалт 2023 оны эхний хагас жилд 3 удаа зарлагдсаныг цагдаагийн газрын нээлттэй пэйж хуудсанд зар тавьж, Өвөрхангай аймгийн телевизэд 1 удаа яриа өгч иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Судалгаанд хамрагдахаар нийт 25 иргэн материал бүрдүүлэн ирсэн. Үүнээс шаардлага хангасан 13 иргэнийг сонгон шалгаруулалтад хамруулсан. Судлагдсан иргэдээс бие бялдар, сэтгэн бодох чадвар, Монгол хэл, Мэргэжлийн шалгалтыг авсан. Шалгалтад тэнцсэн 11 иргэнийг нөөцөд бүртгэгдэж, 9 иргэнийг Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн цагдаа мэргэжил олгох сургалтад хамруулсан байна. Төрийн тусгай алба хаагчийн сонгон шалгаруулалтад орж тэнцэн нөөцөд бүртгэгдсэн иргэдээс 4 иргэнийг тус газарт сул байгаа ажлын байр /албан тушаал/-д томилуулах зөвшөөрлийг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтсээс авч албан тушаалд томилсон.

Хугацааны цол олгогдох хугацаа болсон алба хаагч нарын нэрсийг Хүний нөөцийн сангаас алба хаагч нэг бүрээр тулгалт хийн шүүж цол олгох хугацаа болсон 21 алба хаагчийн материалыг бүрдүүлэн Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн харьяалах албадад хүргүүлсэн. Ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлан ажилласан алба хаагчдыг Төрийн дээд болон Хууль зүй дотоод хэргийн яам, цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнуулах болзол шалгуур хангасан алба хаагчдын материалыг харьяалах албадад хүргүүлсэн.

Алба хаагчдын сарын үндсэн цалин, нэмэгдлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн зэрэглэлийн дагуу цаг тухайд нь тогтоож байгаа ба энэ оны эхний хагас жилийн байдлаар төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэх хугацаа болсон 6 алба хаагч, шинээр томилогдсон 6, офицерын бүрэлдэхүүнд орсон 7, тасаг хэсгийн даргаар дэвшин томилогдсон 1, ахлах албан тушаалд дэвшин томилогдсон 4, албан тушаал өөрчлөгдсөн 17, шилжин ирсэн 5, нийт 46 алба хаагчийн цалингийн зэрэглэл, бусад нэмэгдлийг алба хаагч тус бүрээр шинэчлэн тооцож цагдаагийн газрын даргын тушаал төлөвлөн батлуулж, хүний нөөцийн цахим сан, ХНУМН-ийн сан болон хувийн хэрэгт баяжилт хийн ажилласан.

Цагдаагийн газрын даргын тушаалаар ахлагч бүрэлдэхүүнд томилогдсон 6 алба хаагчид Цагдаагийн газрын даргын тушаалаар сургагч багш томилж, алба хаах гэрээ байгуулж, цагдаагийн байгууллагад хурдан хугацаанд дасан зохицох төлөвлөгөө боловсруулан, цагдаагийн газрын сэтгэл зүйчтэй ганцаарчлан уулзуулан сэтгэл зүйн зөвлөгөө зөвлөмж өгүүлэн, зөрчил дутагдалгүй, байгууллагын албаны нууцыг чанд сахин ажиллах талаар баталгаа авч, алба хаагч бүрт хувийн хавтас нээлгэн тухайн алба хаагчтай холбоотой материалуудыг тус хавтаст хийлгэн үйл ажиллагаанд ашиглан ажиллаж байна. Албан тушаал өөрчлөх хүсэлт гаргасан 29 алба хаагчийн материалыг холбогдох албадад хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Алба хаагчдын ажлын үзүүлэлт, ажилласан жил, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ зэргийг харгалзан 2023 онд офицер албан тушаалын нөөцөд 6, ахлах албан тушаалын нөөцөд 9, тасаг хэсгийн даргын нөөцөд 1, газар хэлтсийн даргын нөөцөд 3 нийт 19 алба хаагчийн материалыг бүрдүүлэн Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн харьяалах албадад хүргүүлж 12 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилуулж шийдвэрлүүлсэн. 2023 оны офицер албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн 7 алба хаагчийн материалыг харьяалах албадад хүргүүлж тус газарт сул байгаа офицер албан тушаалд дэвшүүлэн томилсон. Хүүхэд асрах чөлөө авахыг хүссэн 1 алба хаагчийн материалыг бүрдүүлж Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 1 алба хаагчийн ажилласан жилийн архивын лавлагааг ЦЕГ-ын Төлөвлөлт зохион байгуулалтын

хэлтэс, ЦЕГ-ын Төв архиваас авч материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, цэргийн алба хаасны тэтгэвэрт оруулж шийдвэрлэсэн байна. Хөдөө суманд тасралтгүй 5 жил ажилласан хугацааны мөнгөн урамшуулал авахыг хүссэн 3 алба хаагчийн ажилласан жилийн архивын лавлагааг Цагдаагийн ерөнхий газрын төв архив, ЦЕГ-ын Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсээс авч материалыг бүрдүүлэн ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлсэн.

**Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр:** Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгч нарын хурлаар хэлэлцэн, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/07 дугаар тогтоолоор олон нийтийн цагдаагийн тоо, урамшууллын хэмжээг 2022 онд Арвайхээр сум 7, Хархорин сум 4, Бат-Өлзий сум 1, Уянга сум 3, Сант сум 1, Нарийнтээл сум 4, Бүрд сум 1, Богд сум 1, Баруунбаян-Улаан сум 1, Баянгол сум 1, Төгрөг сум 1, Хужирт сум 1, Есөнзүйл сум 1, нийт 27, нэг олон нийтийн цагдаагийн 1 сарын урамшуулал 480.000 төгрөг байхаар баталсан. Олон нийтийн цагдаагийн нэг алба хаагчид оногдох 1.8 сая төгрөгийг урамшууллыг сумдын Засаг даргын нарын 2022 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн. Цагдаагийн газарт олон нийтийн цагдаагаар сумдад ажиллах хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу судлан цагдаагийн газрын даргын тушаалаар 1 удаагийн сургалт зохион байгуулах тушаал, сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж сургалтыг зохион байгуулсан ба сургалтад хамрагдан гэрчилгээ авсан 7 иргэнийг Олон нийтийн цагдаагийн ажилтнаар томилсон.

**Сахилга ёс зүйн чиглэлээр:**

2023 оны эхний хагас жилд 11 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 9-өөр буюу 45 хувиар буурсан байна. Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл сануулах арга хэмжээ 7, сарын үндсэн цалинг 3 сар 20 буруулах арга хэмжээ авагдсан 4 алба хаагч байна.

Тус газрын Сахилга ёс зүйн орон тооны бус зөвлөл энэ оны эхний хагас жилийн байдлаар 6 удаа хуралдаж, сар бүр зөрчил заагдсан алба хаагчдад арга хэмжээ тооцох, тухай бүр хийх ажлын талаар төлөвлөгөө гарган батлуулж, зөвлөлөөс гарсан шийдвэр зөвлөлийн хурлын тэмдэглэлийг цагдаагийн газрын даргад сар бүрийн эхний 02-ны дотор танилцуулан ажиллаж байна. Алба хаагчдын өдөр тутамд гаргасан алдаа, зөрчил дутагдлыг бүртгэж засуулах чиглэлээр “Зөрчлийн бүртгэлийн дэвтрийг” хөтлөн томилгоот ёс журмын эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн илтгэх хуудаснаас дурдагдсан зөрчлүүдийг бүртгэн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар зөрчлийн бүртгэлд нийт 140 зөрчил бүртгэгдсэн ба Цагдаагийн газрын дотоод журамд заасны дагуу сар бүр нэгтгэн үр дүнг тооцон ажиллаж байна.

“Алба хаагчийн харилцаа хандлагыг дээшлүүлэх” зорилтыг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг боловсруулсан тасаг бүрээс хуваарийн дагуу арга хэмжээ зохион байгуулахаар хуваарилан ажиллаж байна. Мөн алба хаагч нарын дунд спорт, урлаг соёл, эцэг эхийн болон гэр бүлийн зөвлөлтэй хамтран олон талт соён гэгээрүүлэх 13 төрлийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Цагдаагийн газрын алба хаагчдын төрсөн өдрийн арга хэмжээг сар бүрд нь нэгтгэн тасаг бүр хариуцан “Бид нэг хамт олон, өнөөдөр түүний минь төрсөн өдөр” арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчийг нэг өдөр цалинтай чөлөө олгон гэр бүлдээ цаг зав гаргах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна. Эхний 05 дугаар сарын байдлаар 49 алба хаагчдын төрсөн өдрийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

**Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ:**

Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагад дүн шинжилгээ хийж, 2023 онд тус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө гарган, эрх бүхий алба хаагчдыг сурган дадлагажуулах, мэргэшүүлэх чиглэлээр зөрчил заагдсан алба хаагч нараар сургалт явуулах, түүнчлэн алба хаагчдыг хуваарийн дагуу шүүх

хуралд оролцуулж, энэ оны 04 дүгээр сараас 2 сарын хугацаатай “Хуульч ажиллагаа” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Цагдаагийн газарт энэ оны эхний 5 сарын байдлаар Прокурорын газраас 8 прокурорын шаардлага ирүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2-оор өссөн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой 2, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны хүрээнд 6 прокурорын шаардлага ирүүлсэн байна. Ирүүлсэн шаардлагыг ицс санд оруулан, бүртгэлд аван, албаны шалгалт явуулан хариуцсан зөрчил заагдсан 5 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулан, хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Аймгийн прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа, уулзалт, ярилцлага 8 удаа зохион байгуулан ажилласан. Цаашид прокурорын шаардлагад заагдсан зөрчлийг гаргаагүй байх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**Иргэний зөвлөлийн талаар:** Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 06-р сарын 30-ны өдрийн 43 дугаар тогтоолоор иргэний зөвлөл шинэчлэн байгуулагдсан. Иргэний зөвлөлийн гишүүд Бямбын Сүхбат, Насанжаргалын Болортуяа, Баасанхүүгийн Ганбаатар, Сампилын Төмөртоого, Пунцагнамжилын Баярсайхан нар 3 жилийн хугацаатай ажиллаж байна. Цагдаагийн газрын 2022 оны үйл ажиллагааны тайланг иргэний зөвлөлийн гишүүд, иргэдэд танилцуулах арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Орхон синема” кинотеатр зохион байгуулсан. Арга хэмжээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, цагдаагийн газрын дарга, цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүд, алба хаагч нар, Иргэний зөвлөлийн гишүүн П.Баярсайхан, Н.Болортуяа, Арвайхээр сумын 121 иргэд оролцсон. Цагдаагийн газрын 2022 оны үйл ажиллагааны видео тайланг иргэдэд танилцуулан, иргэдээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг авч, хариуцсан албан тушаалтан нараас хариулт өгсөн. Тайланд оролцсон иргэдээс 15 иргэн бичгээр санал гаргасан, 8 иргэн амаар асуулт асууж, санал хэлсэн. Иргэдээс гаргасан саналыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн цагдаагийн газрын 2022 оны үйл ажиллагааны эмхэтгэлийг 44 хуудас, 300 ширхэг хэвлүүлэн иргэний зөвлөлийн гишүүд, иргэдэд танилцуулан ажилласан.

**Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:** 2023 оны эхний хагас жилд нийт 117 өргөдөл, 17 гомдол, хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Үүнээс гомдол, ажилд орох, суралцахыг хүссэн 14, Ажил өөрчлөх, шилжих ажлаас гарах хүсэлт гаргасан 53, Захиргааны чөлөө хүссэн 45, Тэтгэвэр, тэтгэмж орон сууц хүссэн 3, бусад 1 ажилд дахин орохыг хүссэн 1, өргөдөл ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

**/Удирдлага зохион байгуулалтын шинжтэй бүхий л ажил, арга хэмжээг тусгана/**

Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нараас алба алба хаагч нарт ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр 35 үүргийн хуудас, 12 зөвлөмж, зааварчилга 2, цагдаагийн газрын даргаас төлөвлөгөө гаргахаар цохолт хийгдсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу 93 шифр төлөвлөгөөнд дугаар олгож ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3/462 дугаар албан бичгээр ирүүлсэн хуваарийн дагуу цагдаагийн төв байгууллагаас 2023 онд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын хуваарийн дагуу гүйцэтгэлийн шалгалт ирэхтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах /код-112/ журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэж, зөрчил дутагдалгүй хамрагдах бэлтгэл ажлыг ханган, цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн үйл ажиллагаанд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын хуваарь гарган шалгалтыг зохион

байгуулан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2023 онд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын хуваарийн дагуу гүйцэтгэлийн шалгалтыг тус цагдаагийн газарт 2023 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус цагдаагийн газрын үйл ажиллагаанд 2022 онд төлөвлөгөөт бүрэн шалгалтыг 15 нэгж, чиглэлийн ажлыг 109 үзүүлэлт, 449 шалгуурын дагуу явуулж, дүнг Цагдаагийн ерөнхий удирдлагад танилцуулж, тус албаны үйл ажиллагаанд “71.0” буюу “Хангалттай” үнэлгээ өгсөн. Дээрх шалгалтын дүнг үндэслэн тус газарт Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны 6/5347 дугаартай албан бичгээр 33 заалт бүхий үүрэг, ажлын чиглэл хүргүүлж, тус газраас 33 ажил, арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцож, дүнг мөн оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 41/5816 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын даргын нэр дээр хүргүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалт явуулсан ажлын хэсгээс тус цагдаагийн газарт 2022 онд хийгдсэн төлөвлөгөөт бүрэн шалгалтын мөрөөр хүргэсэн 33 заалт бүхий үүрэг, ажлын чиглэлийг хангах чиглэлээр тус газраас зохион байгуулсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг нотломж бүхий материалтай нүд үзэн хянан шалгаж, холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгсөн.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3/462 дугаар албан бичгээр ирүүлсэн хуваарийн дагуу цагдаагийн төв байгууллагаас 2023 онд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын хуваарийн дагуу гүйцэтгэлийн шалгалт ирэхтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах /код-112/ журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэж, зөрчил дутагдалгүй хамрагдах бэлтгэл ажлыг ханган, цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн үйл ажиллагаанд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын хуваарь гарган шалгалтыг зохион байгуулан ажилласан.

Тус цагдаагийн газарт ирүүлсэн үүргийн биелэлт, үр дүнг заалт тус бүрээр тооцож үнэлэхэд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр өгсөн 14 үүргийн заалт “50-89” буюу “Хэрэгжих шатанд”, дундаж үнэлгээ 74.6, тус газрын санхүү, аж ахуйн чиглэлээр өгсөн 6 үүргийн 3 /15-17/ заалт “90-100” буюу “Бүрэн хэрэгжсэн”, 3 /18-20/ заалт “50-89” буюу “Хэрэгжих шатанд” дундаж үнэлгээ 88.0, тус аймгийн Хархорин сумын Сум дундын цагдаагийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр өгсөн 13 үүргийн 9 /22-27,30-31,33/ заалт “90-100” буюу “Бүрэн хэрэгжсэн”, 4 /21,28-29,32/ заалт “50-89” буюу “Хэрэгжих шатанд” дундаж үнэлгээ 87.0, нийт дундаж үнэлгээ 82.0 дүгнэсэн байна. Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагаанд 2022 онд явуулсан төлөвлөгөөт бүрэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгсөн үүргийн биелэлт “82” буюу “Сайн” үнэлэгдэж, бүрэн хэрэгжээгүй ажил арга хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай талаар дүгнэж ирүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 6/5169 дүгээр албан бичгээр ирүүлсэн үүргийн хүрээнд 5 заалттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **ХОЁР: ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

**Гэмт хэрэг, зөрчил:** Өвөрхангай аймгийн цагдаагийн газарт 2023 оны 06 дугаар сарын байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс 2729 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. 378 буюу 13.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2351 буюу 86.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 431 буюу 13.6 хувь, зөрчлийн шинжтэй гомдол 384 буюу 14.0 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 47 буюу 11.1 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 234 буюу 61.9 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 110 буюу 29.1 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж, 10 буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2177 буюу 92.6 хувийг зөрчлийн хэрэг нээж буюу хялбаршуулсан журмаар, 89 буюу 3.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 34 буюу 1.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 22 буюу 6.2 хувийг 5 хоногт, 290 буюу 81.9 хувийг 6-аас 19 хоногт, 42 буюу 11.9 хувийг 20-оос дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 1909 буюу 83.0 хувийг 5 хоногт, 391 буюу 17.0 хувийг 6-аас дээш хоногт шийдвэрлэсэн байна. Гомдол мэдээллийн 75 нь буюу 2.7 хувийг шийдвэрлээгүй, үүнээс гэмт хэргийн шинжтэй 24, зөрчлийн шинжтэй 51 гомдол мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023 оны эхний хоёрдугаар улиралд 211 холбогдогчтой, 454.5 сая төгрөгийн хохиролтой, 288 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 111 хэргээр буюу 27.8 хувиар буурсан, хэргийн илрүүлэлт **55.1** хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс **11.9** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж үзэхэд тус аймагт 288 бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 111 хэргээр буюу 27.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр: Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 100 бүртгэгдэж урьд оны мөн үеийн түвшинд, - Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 13 бүртгэгдэж 6-аар буюу -23.5%-иар, - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 226 бүртгэгдэж 100-аар буюу -44.2%-иар, - Залилах гэмт хэрэг 47 бүртгэгдэж 22-оор буюу -31.9%-иар, - Мал хулгайлах гэмт хэрэг 2 бүртгэгдэж, 15-аар буюу -83.3, - Хулгайлах гэмт хэрэг 59 бүртгэгдэж 59-өөр буюу -50.0%-иар, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдэж 4-өөр буюу -33.3 %-иар, Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 6-аар буюу 54.5%-иар, - хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 17 бүртгэгдэж 5-аар буюу 22.7%-иар, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 3-аар буюу 75.0 хувиар тус тус буурсан. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж, урд оны мөн 10 буюу 2.5 дахин, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн сэрэг гэмт хэрэг 1 дахин тус тус өссөн байна.

2023 оны эхний хоёрдугаар улирлын байдлаар нийт 35379 зөрчил бүртгэгдсэн нь 402 буюу 1.1 хувиар, 34103 иргэнд 988.499.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан нь торгосон хүн өмнөх оны мөн үеэс 506 буюу 1.5хувиар, торгууль 87.017.0 сая буюу 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна .

## **2.1. ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСАГ**

Гүйцэтгэх ажлын эрх бүхий алба хаагч нараас тайлангийн хугацаанд 335 мэдээлэл авч ЭЦА-ны ТТБ-д оруулснаас 8 мэдээлэл танилцуулгад, 1 мэдээлэл онцлогт орсон байна. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 201 гомдол мэдээллийг хэсгийн төлөөлөгч, эрүүгийн мөрдөгч нар хүлээн авч хуулийн дагуу шалгаж 94 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 51 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 40 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж 16 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Нийт хэрэг бүртгэлтийн 606 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж 87 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж 2105 маягтыг шивж, 95 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 14 хэргийг харьяаллын дагуу шилжүүлээд байна. Алба хаагчдын гар дээр шалгагдаж байгаа хэргүүдийг шийдвэрлэх чиглэлээр аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр алба хаагч нарт 09 дугаартай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг тооцсон. Тус оны эхний 05 сарын байдлаар 256 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 93 гэмт хэргээр буюу 26.6 хувь буурсан

ээрэг үзүүлэлттэй. Гэмт хэргийн илрүүлэлт 50.5 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 7.2 хувиар өссөн байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2023 оны эхний хагас жилд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мессеж модемоор текст бэлтгэж нийт 6554 иргэнд мэдээлэл хүргэсэн. Малын хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа Хархорин, Хужирт, Бат-Өлзий сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлыг зохион байгуулж төлөвлөгөө гарган ажиллаж байна. Иргэдээс төлбөртэй мэдээлэл авах ажлыг сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөр дамжуулан зохион байгуулж байна. 2023 оны эхний хагас жилд мал хулгайлах 3 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 11 гэмт хэргээр буюу 78.6 хувиар буурсан эерэг үр дүнтэй ажилласан. “Мал мах” нэгдсэн арга хэмжээг энэ оны 04 дүгээр улиралд зохион явуулахаар төлөвлөсөн.

**Эрэн сурвалжлалтын талаар:** Энэ оны эхний хагас жилийн байдлаар эрэн сурвалжлах санд Оргодол 14, Шүүхээс даалгасан бусад хүн 64, Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн 19, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 65, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 1, тээврийн хэрэгсэл 8, Түүх соёлын дурсгалт зүйл 1, Мал, амьтан 4, эд зүйл 41, Аман зургаар 4, Зөрчил үйлдсэн этгээд 37, нийт 258 эрэн сурвалжлалт зарлан эрэн сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулж 182 эрэн сурвалжлалтыг зогсоож илрүүлэлт 70.5 хувьтай байна. Эрэн сурвалжлах “АСАП” сангийн ашиглалт бүрдүүлэлттэй өдөр бүр танилцаж, алба хаагчдаас санд оруулж буй мэдээ, мэдээллүүдийн үнэн бодитой байдал, алдаа дутагдалгүй байгаа эсэхэд нь хяналт тавьж, гарсан зөрчлүүдийг шуурхай засуулж алба хаагчдад зааварчилж ажилласан. Тус хугацаанд цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах Асап сантай алба хаагчдыг тогтмол танилцуулах чиглэлээр цагдаагийн газрын даргын тушаалаар зохион байгуулагдсан “Эрэн сурвалжлах орон тооны бус зөвлөл”-ийг 14 хоног тутам хуралдуулж шинээр тогтоогдсон нөхцөл байдал, анхаарч ажиллах чиглэлийг тасгийн дарга нарт өгч ажиллав. Тус хугацаанд эрэн сурвалжлах “Асап” сантай алба хаагчдаас 85650 удаа танилцаж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Цагдаагийн газрын алба хаагчид “ЦБҮАЖ код-307”-д зааснаар дараах 27 алба хаагч, 50 илтгэх хуудас санд шивж оруулсан байна.

## **2.2. ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСАГ**

Тус тасгаас энэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж цагдаагийн газрын даргаар батлуулан, тасгийн алба хаагч нартай тасгийн даргаас гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тасгаас “Албаны сургалт”, “Соён гэгээрүүлэх ажил”, “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, бусад ажлын хэсэг, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулан ажиллав.

Мөн санхүүгийн тайлан мэдээ, /шилэн дансны мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, ил тод байдлын мэдээ, үнэт цаасны тайлан, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого, татварын тайлан, нийгмийн даатгал шимтгэлийн тайлан, бараа, материалын тайлан/ тухай бүр чанартай, үр дүнтэй хугацаанд нь гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн алба, аймгийн аудитын газар, аймгийн төрийн сангийн хэлтэс, орон нутгийн өмчийн газар, татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн ажилласан. Цагдаагийн газрын архивын чиглэлээр хийгдэх төлөвлөгөө гарган батлуулан ажиллав. Цагдаагийн газрын даргаас хэлтэс, тасгийн дарга нарт албан бичгээр хуваарь хүргүүлж, 2022 онд үүссэн архивын баримтын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт гарган ажилласан. Цагдаагийн газрын архивд цахимжуулсан файлыг нэгтгэн цахим архив үүсгэн ажиллаж байна.

Тус газраас 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт, хариуцах албан тушаалтныг 2023 оны А/19 дугаар тушаалаар баталгаажуулан,

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журамд нийцүүлэн хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, тогтоосон хугацаанд холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд хагас жилийн байдлаар хүргүүлэн ажиллаж байна.

**Ахмадын зөвлөлтэй хамтран ажиллах ажлын хүрээнд:** Цагдаагийн газраас ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг цагдаагийн газрын даргын 2022 оны А/28 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. 2023 оны төлөвлөгөөг 23 заалттай гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус цагдаагийн газрын ахмад ажилтан 52, Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтсийн 21 ахмад ажилтан нарын талаарх бүртгэл, судалгаанд баяжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалаар “Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх баг”-ийг 7 ахмад ажилтны бүрэлдэхүүнтэй шинээр байгуулан, 15 заалттай төлөвлөгөөг гаргаж, ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Сүхбаатарын одонт ба Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цагдаагийн албаны туг болон Дотоодын цэргийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, “Цагдаагийн тангараг” давтах ёслолын арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын төв “Аюуш баатар”-ын талбайд зохион байгуулагдсан. Арга хэмжээнд цагдаагийн газрын нийт 30 ахмад ажилтан нар оролцсон. Сар шинийн баяраар цагдаагийн газрын 51 ахмад ажилтанд 2.1 сая төгрөгийн гарын бэлэг, Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтсийн нийт 21 ахмад ажилтанд 730,000 төгрөгийн сар шинийн гарын бэлэг өгч, өндөр настай 5 ахмад ажилтанд цагдаагийн газар, хэлтсийн дарга нараас хүндэтгэл үзүүлэн ажилласан. Цагдаагийн газрын болон хэлтсийн нийт 73 ахмад ажилтын нийт 32 ахмад ажилтанд ахмадын үнэмлэх захиалан авсан.

Аймгийн ахмадын хороо, цагдаагийн газрын ахмадын зөвлөлтэй хамтран ахмадуудын дунд “Баясах өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Төрийн дээд одон медальд 5 ахмад ажилтныг тодорхойлсон байна. Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоогдсон 1 алба хаагчид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

**Сэтгэл зүйн чиглэлээр:** Тус газраас тэтгэвэрт гарах алба хаагчдын амьдралын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгааг 23 алба хаагчаас, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 20 алба хаагчаас Айзенк, мичиган судалгааг авч боловсруулалт хийж тодорхойлолт гаргасан. Тус цагдаагийн газрын нийт алба хаагчдаас цахим сангийн 6 төрлийн судалгааг авахад давхардсан тоогоор нийт 656 алба хаагч хамрагдаж, судалгааны үр дүн гарсан. Сонгон шалгаруулалтад орох 5 иргэнтэй ярилцлага хийж, судалгааг авч, дүнг холбогдох газарт цахимаар хүргүүлэв. Гэрч, хохирогч, мөрдөгчийн даалгавар хүлээн авч, хохирогчтой уулзан судалгаа авч, 2 удаа уулзаж ярилцан зөвлөгөө өгсөн. Өөрийн чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 5 алба хаагчтай уулзаж, холбогдох судалгааг авч, боловсруулалт хийсэн. “Сэтгэл зүйн тогтвортой байдалд спортын үзүүлэх нөлөө” сэдвээр видео сургалт бэлтгэн Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газарт хүргүүлэв.

**Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/45 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагдаагийн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай” А/18 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төлөвлөгөө гарган хэлтэс, тасагт хүргүүлэн сургалт зохион байгуулан биелэлт үр дүнг тооцож ажиллаж байна. 2023 оны хагас жилд соён гэгээрүүлэх чиглэлээр 73 ажил, арга хэмжээ зохион байгуулснаас мэдээлэл сурталчилгааны чиглэлээр 34, соёл хүмүүжлийн чиглэлээр 39 арга хэмжээ зохион байгуулж



давхардсан тоогоор 11008 алба хаагч хамрагдсан.

Тус газраас санаачлан “Урлагийн бага наадам”-ыг алба хаагчдын дунд Монгол үндэсний урлагийн их өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, алба хаагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, харилцан бие биеэсээ суралцах зорилгоор урлагийн бага наадмын удирдамжийг боловсруулан батлуулж, сумдын хэлтэс, тасагт хүргүүлж, “Урлагийн бага наадам”-ыг энэ оны 02 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгуулсан. Энэхүү урлагийн бага наадамд сум дундын хэлтэс, тасаг болон төвийн тасгийн алба хаагчдын нийт 12 багийн 160 гаруй алба хаагчид 8 төрлөөр авьяас билэг, ур чадвараараа өрсөлдөн, “Тэргүүн байр”-ыг Уянга сумын сум дундын цагдаагийн тасгийн “Эх орон” баг, “Дэд байр”-ыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн “Янжинлхам” баг, “Гутгаар байр”-ыг Эрүүгийн цагдаагийн тасгийн “Нүнжиг” баг, “Тусгай байр”-ыг Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтсийн “Magic” баг тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар, шилдгийн шилдэг үзүүлбэрээр “Янжинлхам” багийн хамтлаг дуу шалгарч, “Гран-при”-ийн цомын эзнээр тодорсон.

**Сургалтын чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/46 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газрын даргын 2023 оны “Албаны сургалтын төлөвлөгөө гаргаж батлах тухай” А/17 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гарган Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтэс, Уянга, Богд сумын сум дундын цагдаагийн тасагт хүргүүлэн сургалт зохион байгуулан биелэлт үр дүнг тооцож ажилласан. Сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн Мягмар гарагт нэгдсэн сургалт, Пүрэв гараг бүр тасгийн сургалт зохион байгуулж байхаар төлөвлөсөн. Сургалт зохион байгуулахдаа тасгийн дарга нараар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-аар сургалтын материал бэлтгүүлж сургалт зохион байгуулсан. Энэ оны хагас жилд 47 сургалт зохион байгуулагдаж давхардсан тоогоор 6707 алба хаагч хамрагдсан.

**Алба хаагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:** Алба хаагч, ажилтан нараас орон сууцанд хамрагдах судалгааг авч, орон сууцны газрыг шийдвэрлүүлэхээр аймгийн удирдлагад хүсэлт хүргүүлсэн.

Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Ариун алтан бумба” ХХК-иар 10 давхар орон сууц барих гэрээ байгуулан нийт 27 алба хаагч, 5 ахмад ажилтан байр захилга өгч, суурийн цутгалтын ажил эхэлсэн бөгөөд 2024 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Цагдаагийн газрын даргын 2023 оны 02-р сарын 01-ний өдөр баталсан “Алба хаагч нарын ар гэрийн гишүүдийн санал хүсэлтийг сонсох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр “Танилцаж-Туслая” аяныг зохион байгуулан тасгийн дарга нараас алба хаагч нарын ар гэрээр орж ахуй амьдралтай танилцаж санал хүсэлтийг авч ажилласан. Мөн тасгуудаас алба хаагч нараас сонгон дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажилласан. Аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, “Чин мэнд” эмнэлэг, сумдын эрүү мэндийн төвүүдтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулан дүгнэж, 45 алба хаагчийг дархлаажуулан, 3 алба хаагчийг 7 хоног “Сүүж уул”-ын сувилалд амраасан, 25 алба хаагчийг эмийн эмчилгээнд, 4 алба хаагчийг хэвтэн эмчлүүлсэн байна.

Энэ онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал, албаны шуурхай байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд сумдын албан хаагч нарт нэн тэргүүнд шаардлагатай албаны автомашин, мотоциклоор хангах талаар Цагдаагийн газрын дарга, сумдын Засаг дарга, хэсгийн

төлөөлөгч нарын хамтын ажиллагааны гурвалсан гэрээнд тусган батлуулж тухайн гэрээний хүрээнд Баян-Өндөр, Бүрд сум орон нутгийн хөрөнгө оруулалтаар тус бүр 20 сая төгрөгөөр Toyota Probox автомашин, Сант сум 3 сая төгрөгөөр мотоциклыг шийдвэрлүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байна.

Цагдаагийн газрын “Сургалт дадлагын төв”-ийг өргөжүүлэх, бүтээн байгуулалт, тохижилтын ажил хийх зорилгоор 2023 хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 17 заалттай гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цагдаагийн газрын “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд мод тарих, цэцэгжүүлэх аяныг “Сургалт дадлагын төв”-д энэ оны 5 сард зохион байгуулж, 5 төрлийн 1565 ширхэг модны суулгац суулгасан.

Гэр бүлийн зөвлөгөөнийг "Миний гэр бүл-Миний аз жаргал" хүүхдийн баярын арга хэмжээтэй хамтруулан энэ оны 05 сарын 28-ны өдөр цагдаагийн газрын сургалт дадлагын төвд зохион байгуулсан.

Зөвлөгөөнд алба хаагчдын гэр бүлийн гишүүдээс 45 иргэн оролцон санал, хүсэлтийг авч ажилласан.

Бүтээн байгуулалтын чиглэлээр сургалтын төвийн гэр заалны гадна талын дээврийг төмөрлөж, дотор талын засал, шатсан гэрлүүдийг солих, тасгуудын байрны дээврийг хүрэн өнгөөр будах, шинээр 1 амрах байрыг барьж ашиглалтад авч, засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэв. Явган хүний зам дагуух хаалт хийж тросс татаж, хоёр хүлэмжинд 6 төрлийн ногооны суулгац суулгаж тарьсан.

Цагдаагийн газрын сургалт дадлагын төв, цагдаагийн газрын конторын байрны гадна талбайг зүлэгжүүлж, цэцэгжүүлсэн. Сургалт дадлагын төвд нийт 10 нэр төрлийн 9822 ширхэг модыг арчилан ажиллаж байна. Тарагт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Бат цэцэрлэгжилт” ХХК-тай хамтран Арвайхээр сумын нутаг дэвсгэрт 2 га газарт, мод тарьж ургуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагаас "Нэг сая мод" тарих төлөвлөгөөний хүрээнд цагдаагийн газраас “Сургалт дадлагын төв, "Баян Намсрай" цэцэрлэгт хүрээлэн, сумдын кобан байрны ойр орчим хашаандаа Шар хуайс-800, улиас-200, чацаргана-80, гацуур-20, хайлаас зэрэг 1100 ширхэг мод тарьсан. Цагдаагийн газрын “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд “Нэг мод -Нэг насны буян” мод тарих, цэцэгжүүлэх аяныг “Сургалт дадлагын төв”, энэ оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс энэ оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулав. Сургалтын төвд хайлаас 400 ширхэг, 30 ширхэг шинэс, 15 ширхэг бургас, 10 ширхэг чацаргана, 10 ширхэг үхрийг нүдний мод нийт 465 ширхэг модны суулгац суулган тарьсан. Нийт цагдаагийн газрын хэмжээнд 1565 ширхэг модны үсэлгээ суулгасан байна.

Хужирт сумын цагдаагийн тасгийн байрыг барьж ашиглалтад оруулахаар “Гүнчимэгтэй” ХХК шалгарч гурвалсан гэрээг 2021 оны 05-р сарын 24-ний өдөр байгуулан барилгын ажлыг 2021 оны 11-р сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр тусгасан боловч гэрээний хугацаанд гүйцэтгээгүй. Энэ онд гэрээний хугацааг сунгаж 2023 оны 06 дүгээр сарын 1-ний өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээг сунгасан боловч, хугацаандаа хийж гүйцэтгээгүй байна. Цагдаагийн тасгийн байр нь 380 сая төгрөгийн өртөгтэй, 2 давхар, 360 м2 метр квадрат, 19 өрөө, 2 автомашины гражтай. Хужирт сумын цагдаагийн тасгийн шинэ байрны барилгын ажил энэ оны 5 сард эхлэн гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Энэ оны 07 сард ашиглалтад өгөхөөр гэрээг сунгасан байна.

### **2.3. МӨРДӨН БАЙЦААХ ТАСАГ**

Тус тасаг нь 2023 оны эхний хагас жилд 179 гомдол мэдээлэл хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үед 206 гомдол мэдээлэл

хүлээн авч шалгасантай харьцуулахад 27 гомдол мэдээллээр буюу 13.1 хувиар буурсан байна. Хүлээн авсан 153 гомдол мэдээллийн 137 гомдол мэдээллийг шийдвэрлэж, 16 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй, гомдол мэдээллийн шийдвэрлэлт 89.5 хувьтай байна. 2023 онд бүртгэгдсэн хэрэг бүртгэлтийн өмнөх оны дугаартай 62 хэрэг, энэ оны дугаартай 147 хэрэг, нийт 209 хэрэг шалгаснаас 188 хэргийг шийдвэрлэж, хэргийн шийдвэрлэлт 89.9 хувьтай, 21 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын урьд оны дугаартай 6 хэрэг, энэ оны дугаартай 226 хэрэг, нийт 232 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 224 хэргийг шийдвэрлэж, 8 хэргийн үлдэгдэлтэй, хэргийн шийдвэрлэлт 96.5 хувьтай байна.

Өмнөх оны дугаартай өмнөх оны үлдэгдэл 68 хэргээс 66 хэргийг шийдвэрлэж, хэргийн шийдвэрлэлт 97.0 хувьтай байна. Энэ оны эхний хагас жилд прокуророос нэмэлт ажиллагаа хийлгэхээр 4 хэрэг буцсан нь нийт шийдсэн хэргийн 1.7 хувийг эзэлж байна. Тус тасагт яллагдагч оргон зайлсан болон бусад үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг байхгүй байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шалгасан хэргээс 52.1 хувьд тасгийн даргын зааварчилга бичиж, биелэлтийг тооцож ажиллаа.

Гэмт хэргийн улмаас 132.437.527 төгрөгийн хохирол учирснаас 126.423.516 төгрөгийн хохирол нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 95.4 хувьтай байна. Нуугдмал хөрөнгө илрүүлэх зорилгоор хөрөнгө битүүмжлээгүй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт 82.7 хувьтай, нийт шалгасан хэргийн 37.6 хувьд 2105 маягтыг шивж ажилласан. Нийт шалгасан 179 гомдлоос 72 гомдлыг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэргийн хувь 40.2 байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 86 бүртгэгдэж, 79 хэргийг илрүүлж, хэргийн илрүүлэлт 94.0 хувьтай, хэргийн шийдвэрлэлт 90.6 хувьтай байна. Одоо тус тасагт хэрэг бүртгэлтийн 21, мөрдөн байцаалтын 8 хэрэг, нийт 29 хэргийн үлдэгдэлтэй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Мөрдөн байцаах албаны Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд урьд оны дугаартай хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шийдвэрлэх зорилгоор зохион явуулж буй “Илрүүлэлт шийдвэрлэлт-1” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулж байна. Уг арга хэмжээний хүрээнд шийдвэрлэхээр урьд оны дугаартай 1 хэрэг, энэ оны дугаартай 17 хэрэг, нийт 18 хэргийг графикт оруулснаас 10 хэргийг шийдвэрлэж, 8 хэргийн үлдэгдэлтэй байгаа ба өмнөх оны хэргийн шийдвэрлэлт 100 хувьтай, энэ оны хэргийн шийдвэрлэлт 52.9 хувьтай байна.

Мөн Залилах гэмт хэрэг мөрдөх хэлтсээс зохион явуулсан “Шийдвэрлэлт 1, 2” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулснаар залилах төрлийн гэмт хэрэг 13 хэргээр буюу 16.2 хувиар буурсан байна. Мөрдөгч нараас 2023 оны эхний хагас жилд 53 удаа хүн нас барсан хэргийн газрын үзлэг, задлан шинжилгээнд оролцож ажилласан. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 5 яллагдагчид авсан ба хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж ажилласан.

Бусад газраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийлгэхээр 42 мөрдөгчийн даалгавар ирүүлснийг хүлээн авч бүртгэлд оруулан, даалгаварт заагдсан ажиллагааг гүйцэтгэн хариуг хүргүүлсэн.

Гэмт хэргийн мэдээллийн санд гомдол мэдээлэл, хэргийн мэдээллийг тухай бүр бүртгэж, хяналтыг өдөр бүр тавьж, зөрчлийг засуулан ажилласан. 2023 оны эхний хагас жилд гэмт хэргийн 789 мэдээлэл бүртгэгдсэнээс 756 мэдээллийг хянасан төлөвт оруулж, мэдээллийн сангийн хяналт 99.5 хувьтай байна.

#### **2.4. ЗАМЫН ЦАГДААГИЙН ТАСАГ**

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онуудад гарсан зам тээврийн ослын хар цэгүүдэд судалгаа шинжилгээ хийн нутаг дэвсгэрээр нь магистрал зам дамжин өнгөрдөг Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан, Богд, Хужирт зэрэг 8 сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг цагийн менежментээр ээлжээр өдөр бүр ажиллуулж байна.

Цагийн менежментээр сумдын алба хаагчдыг ажиллуулснаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 73 зөрчил илрүүлж, хурдыг 10-50 хүртэл хувиар хэтрүүлсэн 195 жолоочийг 9.750.000 төгрөгөөр, бусад зөрчилтэй 4536 хүнд 101.498.000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар давхардсан тоогоор 129.242 тээврийн хэрэгсэл шалгаж 27536 зөрчил илрүүлж ажилласан байна.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 469 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1, 2-д заасны дагуу 1 жилийн хугацаагаар хасаж 187.600.000 төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 372 жолоочийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 103 хүнд 20.200.000 төгрөгийн торгууль, бусад зөрчил гаргасан 26529 жолоочийг 582.980.009 төгрөгөөр торгож Цагдаагийн ерөнхий газрын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажилласан.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай удирдлагын тасгийн 102 дугаарын утсанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 32 гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-202-ын дагуу хүлээн авснаас ослын газрын үзлэг хэмжилт хийж 16 гомдол мэдээллийг харьяаллын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт шилжүүлэн ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг болон илрүүлсэн зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт.

№	Харьцуулсан хугацаа	Осол хэрэг, зөрчлийн судалгаа								
		Нийт осол	Хэрэг	Нас барсан	Гэмтсэн	Илрүүлсэн зөрчил	Торгосон		СТХЖ	
							Хүн	Төг	14.7.3.1	14.7.5
1	2022 он эхний хагас жил	61	23	18	21	34384	33284	780.473.760	541	404

2	2023 он эхний хагас жил	32	16	7	12	27536	26529	582.680.009	469	372
3	Хувь	47.6% буурсан	30.5% буурсан	61.2% буурсан	42.9% буурсан	20.1% буурсан	20.3% буурсан	24.9% буурсан	13.4% буурсан	8% буурсан

### Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас “Халтиргаа”, “Мотоцикл ба хамгаалах малгай”, “Цагийн менежмент”, “Сар шинэ-2023”, “Уусан бол бүү жолоод”, “Автомашин утаа”, “Тээврийн хэрэгслийн утаа”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Оношилгоо”, “Урьтаж-Ухаар”, “Албан мэдэгдэл”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг Тээврийн цагдаагийн албаны даргаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, цагдаагийн газрын даргаар батлуулж, Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтэс, Уянга, Богд сумын сум дундын цагдаагийн тасаг, Хужирт, Бат-Өлзий сумын цагдаагийн тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Арвайхээр сумын 13 багт байрлах сургууль, цэцэрлэг, шатахуун түгээх станц, авто засвар, машин угаалгын судалгааг шинэчлэн гаргасан.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг Нарийнтээл, Хархорины болон Онгийн голын байнгын хяналтын 3 пост, Бүрд, Есөн зүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан, Хужирт сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа, экологийн асуудал хариуцсан байцаагч нарыг цагийн менежментээр үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Аймгийн Ерөнхий боловсролын сургууль орчим сурагч явганаар хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэлийн үнэлгээг гарган Тээврийн цагдаагийн алба руу хүргүүлж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гаргаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад төслөөр танилцуулан, шинээр хийх болон хуучирч муудсан, өнгө будаг нь арилж утгаа алдсан 170 тэмдгийг солиулах судалгааг гарган, хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлсэн.

Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, жолооч нарын сахилга хариуцлагад хяналт тавьж анхааруулж сануулан болзошгүй осол зөрчлөөс урьдчилан сэргийлж нийт 27536 зөрчил илрүүлж үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 904, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 103, хурд хэтрүүлсэн 539 зөрчил илрүүлж, нийт 26529 жолоочийг 582.680.009 төгрөгөөр торгож арга хэмжээ авч, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн гаргасан 150 төрлийн шторк, 110 төрлийн зурагт хуудсыг Цагдаагийн газрын нээлттэй фэйсбүүк цахим хуудаснаас хандалт ихтэй фэйсбүүк хуудсанд түгээж, учирч болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлж ажилласан.

Зам тээврийн хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг бууруулах чиглэлээр аж ахуйн нэгжид 47 мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж хариуг хугацаанд авч ажилласан.

БАЯНТЭЭГ” ХК-ны захирал Н.Данзан, аймгийн Иргэдийн хурлын дарга О.Пүрэвдорж, “ӨВӨРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ны захирал Д.Лхам-Оролмаа, Автотээврийн төвийн дарга Д.Амартүвшин, Арвайхээр ОНӨААТҮГ дарга Д.Сүх-

Өлзий нартай Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрээр Өвөрхангай-Улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай А0301, Өвөрхангай-Баянхонгор чиглэлийн А0302, Хархорин-Улаанбаатар чиглэлийн А0601, Хархорин-Архангай чиглэлийн А0602 дугаартай улсын чанартай авто замуудын даац нь MNS4598:2020 Монгол улсын стандартад заагдсан жин тоннтой тээврийн хэрэгсэл зорчиход зориулагдсан бөгөөд зорчиж байгаа тээврийн хэрэгслүүдийн бүх жин хэтэрснээс авто замуудад эвдрэл үүсэж иргэдийн аюулгүй зорчих нөхцөл хаагдахад хүрч байгаа талаар уулзалт хийсэн.

Зам тээврийн осол хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын засаж болохоор зөрчлийг газар дээр жолооч нарт ойлгуулж зөрчлөө арилгасан тохиолдолд торгохоос татгалзаж нийт-17500 жолоочид "ИТГЭЛИЙН ХУУДАС"- ийг олгоно ажилсан.

### **Гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх хяналт тавих чиглэлээр:**

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 469 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1, 2-д заасны дагуу 1 жилийн хугацаагаар хасаж 187.600.000 төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 372 жолоочийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 103 хүнд 20.200.000 төгрөгийн торгууль, бусад зөрчил гаргасан 26529 жолоочийг 582.980.009 төгрөгөөр торгож Цагдаагийн ерөнхий газрын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажилласан.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай удирдлагын тасгийн 102 дугаарын утсанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 32 гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-202-ын дагуу хүлээн авснаас ослын газрын үзлэг хэмжилт хийж 16 гомдол мэдээллийг харьяаллын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт шилжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/44 дүгээр тушаалаар баталсан “Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих /код409/ журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 04 дүгээр сард Замын цагдаагийн дарга, ахлах зохицуулагч нар аймгийн хэмжээний Цагдаагийн байгууллагын Зөрчлийн нэгдсэн сангийн зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн 3112, 3110 дээр шивэгдсэн мэдээлэлд хяналт тавьж ажилласан. Улсын Ерөнхий прокурорын А/54 дүгээр тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийг зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад бүрэн танилцуулж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдаас энэ төрлийн зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр тогтмол үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Аймгийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьдаг хяналт прокурортой 15 удаа уулзаж санал солилцон ажилласан.

Улсын Ерөнхий прокурорын А/54 дүгээр тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийг зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад бүрэн танилцуулж, энэ төрлийн зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр баталгааны хэрэгжилтийг ханган ажилласан.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрлэгдээгүй удсан 19 хэрэгт хийгдэх шаардлагатай ажиллагааг хийх талаар зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### **2.5. НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ТАСАГ**

2023 оны эхний хагас жилийн байдлаар хэв журмын 922 зөрчил илрүүлж, урьд оны мөн үетэй харьцуулахад 184 нэгжээр буюу 24.9 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Нийт илрүүлсэн зөрчлийн 113 нь буюу 12.2 хувь нь бэлэн бус торгуулийн багажаар торгосон зөрчил байна. 297 гомдол мэдээлэл хүлээн авч 98 хэрэгт хэргийн хэрэг бүртгэлт явуулж, хялбаршуулсан журмаар 172, татгалзсан 25, харьяаллын дагуу 6 шийдвэрлэж, үлдэгдэл 11 зөрчлийн хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

**Хэв журмын зөрчлийн илрүүлэлт:** Хэв журам, замын цагдаагийн чиглэлээр 6652 иргэнийг 137.184.109 төгрөг торгож, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 34 нэгж буюу -8%-иар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 65 нэгж буюу -27%-иар, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 10 нэгж буюу -60%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

**Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах:** Өвөрхангай аймгийн Арвайхээр шүүхийн байранд харуулын 4 цагдаа 4 ээлжээр 24 цагаар үүрэг гүйцэтгэж 345 иргэн, Хархорин сум дахь сум дундын шүүхэд харуулын 4 цагдаа 24 цагаар үүрэг гүйцэтгэж 244 иргэний бичиг баримтыг шалган бүртгэж, түр үнэмлэх олгон шүүхийн байранд нэвтрүүлж ажилласан ба ямар нэгэн зөрчил илрээгүй. Овор хэмжээтэй ачаа тээшинд үзлэг хийж, тээш хадгалах саванд түр хадгалуулж ажилласан байна. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангаж ажиллах хугацаанд шүүх хуралдааны оролцогчдоос шүүх хурлын дэг зөрчсөн зөрчил дутагдал гараагүй шүүх хуралдаан тасралтгүй хэвийн явагдсан.

Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх цагдан хорих байрнаас шүүхийн байранд 22 удаа хуяглан хүргэлт, шүүхийн байрнаас цагдан хорих байранд нийт 26 удаа хуяглан хүргэлтийг томилгоо, зураглал гарган ердийн байдлаар, явганаар 48 удаа 48 шүүгдэгчийг хуяглан хүргэж ажилласан.

Өвөрхангай аймгийн сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 1 гэрч, 2 иргэний хариуцагчийг албадан ирүүлсэн, Хархорин сум дахь сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхээс 4 иргэний хариуцагчийг албадан ирүүлсэн.

Тус цагдаагийн газарт шүүхээс даалгасан иргэний хариуцагчаар “Asap” санд 4 иргэнийг зарлаж, 2 иргэний хариуцагчийг олж тогтоосон.

Шүүхээс даалгасан этгээдийг олж тогтоох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр “Шүүхээс даалгасан бусад хүн-2023” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө, судалгааг гарган газрын даргаар батлуулж, энэ оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 16-ны өдрийн хооронд 40 хоногийн хугацаатай аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд шүүхээс эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг мэдээллийг нийт алба хаагч нарт “Power point” зурган хэлбэрээр танилцуулж, мэдээлэл солилцон, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт 05 дугаар сарын 05-ны өдрийн 34 дугаартай “Үүргийн хуудас”-ийг хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн “Asap” санд шинээр орсон иргэний мэдээллийг эрэн сурвалжлах холбогдох мэдээллийг байршуулан нийт алба хаагчдад танилцуулан ажиллаж, цаашид шүүхээс даалгасан иргэний хариуцагчийг эрэн сурвалжилж олж тогтоох чиглэлээр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Эрэн сурвалжлах код-229.3 заасны дагуу ажиллаж байна.

**Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагааны талаар:**

Тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байраар 2023 оны эхний хагас жилийн байдлаар захиргааны зөрчилд холбогдож албадан саатуулсан 87, эрүүлжүүлсэн 8, эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хурлын шийтгэврээр 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл ногдуулсан 381 хүнийг тус байранд хүлээн авч, хууль, журамд заасны дагуу албадлагын арга хэмжээ авч ажилласан байна.

Шүүхийн шийтгэвэрт заасан албадан сургалтын хуваарийн дагуу баривчлах

шийтгэл ногдуулсан 381 иргэнд давхардсан тоогоор 166 удаагийн 332 цагийн албадан сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг тус цагдаагийн газрын сэтгэл зүйч, замын цагдаагийн тасгийн зохицуулагч, хэсгийн байцаагч, багийн цагдаа, эмч, ГБХ-тэй тэмцэх ахлах мэргэжилтэн, ГХУС ахлах мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллагын сургагч багш нартай хамтран зохион байгуулж байна.

Баривчлах шийтгэл ногдуулсан иргэдийн гарын хээний дардас болон бусад холбогдох мэдээллийг шүүх шинжилгээний албаны мэргэжилтнээр папилон санд эхний хагас жилд 233 иргэний гарын дардсыг бүртгүүлж ажилласан.

Баривчлагдсан 381 иргэний баривчлах байрны зардал нийт 8.030.900 төгрөгийг хураан авч төрийн сангийн 100100012001 тоот дансанд тушааж, тус газрын санхүүтэй тооцоо хийн ажилласан. Гудамж талбай олон нийтийн газар биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 35 иргэнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, эрүүлжүүлэгдсэн 8, саатуулагдсан 87 этгээдийн түр хураалгасан эд зүйлсийг хөндлөнгийн гэрч байлцуулан хүлээлгэн өгч гарын үсэг зуруулж дараа өдрийн 12 цагаас өмнө зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд нь хүлээлгэн өгч ажилласан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаанд 21 ширхэг 16 сувгийн 2 DVR хяналтын камераар жижүүрийн цагдаа, эмч нар биечлэн тогтмол хяналт тавин ажиллаж байна. Хяналтаар цагдаагийн газрын ёс журам сахиулах эргүүл, томилгоот дарга, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нар өдөр тутам хяналт тавьж, үүрэг ажлын чиглэл өгч ажилласан.

Эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан болон баривчлагдсан иргэдийн мэдээллийг цагдаагийн байгууллагын цахим бүртгэлийн санд тухай бүрт шивж тасгийн дарга, ахлах, мэдээлэл судалгааны мэргэжилтэн нараар тогтмол хянуулан ажиллаж байна. Мөн өдөр бүр хяналтын прокурорт эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны нөхцөл байдлын мэдээг өгч, сар бүрийн 15, 30-ны өдрүүдээр тасалбар болгон эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан, баривчлагдсан иргэдийн мэдээллийг хүргүүлсэн. Тус байранд өдөр тутамд хөтлөгддөг 31 бүртгэлүүдийг 7 алба хаагчдад хариуцуулан бүртгэлүүдийг зохих журмын дагуу хөтлөж, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Томуу, томуу төст өвчний халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны гадна болон дотно орчныг шүүхийн шийтгэврээр баривчлагдсан иргэдээр тогтмол хийлгэж, жавелионы 0,03%-ийн уусмалаар ариутгаж бүх хөнжил, цагаан хэрэглэл, бүтээлгийг угаалгаж, хлораминтай уусмалаар өдөр бүр байрны өрөө тасалгаа, камеруудад цэвэрлэгээ хийлгэж, цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн тухай бүртгэлд тогтмол тэмдэглэгээг хийж байна.

Цагдаагийн газрын нягтлан, няравт цэвэрлэгээний материалын зарцуулалтыг гарган өгч 2 удаа шаардах хуудсаар ариутгалын бодис, цэвэрлэгээний материал авч өдөр бүр цэвэрлэгээ хийлгэж ашигласан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх, албаны бэлэн байдлыг хангах, Монгол улсын стандарт MNS 5527:2019 стандартад нийцүүлэх зорилгоор 508500 төгрөгийн эм тариа, ороох боох материал, эмнэлгийн багаж хэрэгслийг татан авч эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн.

Баривчлагдсан иргэдэд олгож буй хоолны илчлэг, чанар нормыг хангах зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын лабораторид 1 дүгээр улирлын хоолны дээж хүргүүлж шинжилгээнд хамруулахад Баривчлах байрны дотоод журам А/246-д заасан нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэгийн хэмжээ 2800 ккал-оос багагүй байна гэх заалтыг хангасан.

### **Монгол банкны харуулын үйл ажиллагаа:**

Монгол банкны дэд ерөнхийлөгч, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын



даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 11-02622/124 дугаартай хамгаалалтын ажил гүйцэтгэх хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу хамгаалалтын үйл ажиллагааг явуулж байна.

Өвөрхангай аймаг дахь Монгол банкны хэлтсийн байранд харуулын үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчид Монгол банкинд нэвтрэх заавар, журмын даруу арилжааны Хаан банк, Төрийн банк, Хас банк, Голомт банкнууд 170 удаа нэвтэрч 170 мөнгө тушаалт, 1 зузаатгал авч, Монгол банк руу орж, гарч буй 150 иргэнийг журмын дагуу нэвтрүүлж ажилласан.

Төв Монгол банкнаас энэ оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний хооронд зузаатгал авч, зузаатгал авах үеийн хамгаалалтад цагдаагийн газраас 8 алба хаагч ажиллаж, хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан. Гэрээний дагуу Монгол банкны дохиолол 2 удаа дуугарсан ба хамгаалалтыг шалгах зорилгоор 2 удаа, хамгаалалтыг шалгахад ямар нэгэн зөрчил гараагүй болно.

#### **Албаны галт зэвсгийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр:**

ЦЕГ-ын даргын 2017 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх биедээ авч явах, олгох журам”, мөн даргын 2019 оны А/235 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох, буудлага хийх журам”-д заасны дагуу тус газрын албаны галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийг данс бүртгэлийг сайжруулах, зөрүүтэй зөрчлийг арилгах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тус цагдаагийн газрын даргын тушаал гарган албаны галт зэвсэг, галт хэрэглэлд тооллого явуулах ажлын хэсгийн гишүүдийг томилж, төлөвлөгөөг батлан, албаны галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийн хадгалалт хамгаалалт, аюулгүй ажиллагаа, үзлэг тооллого, зэвсгийн агуулах өрөө, /сейф/-д нэвтрэх, гамшиг ослын үед ажиллах болон зэвсэг хэрэгсэлд үзлэг хийх хуваарь гарган, албаны галт зэвсэг, хэрэглэлд үзлэг, тооллого явуулж, биечлэн хяналт тавьж дүнг тооцож ажиллаж байна.

Аймгийн цагдаагийн газар, хэлтсийн даргын тушаалаар албаны галт зэвсэг, хэрэгсэл хариуцах алба хаагчаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Х.Батпүрэв, Нийтийн хэв журам хамгаалах хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Дэлгэрнасан нарыг тус тус томилж, гамшиг ослын үед ажиллах болон зэвсэг, хэрэгсэлд үзлэгийг улирал бүр зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажилласан.

Албаны галт зэвсэг, хэрэгслийг байгууллагын В1 давхарт байрлах өрөөнд тусгай төмөр сейфэнд хадгалж, дайзыг галт зэвсгээс салгаж тусад нь байрлуулж, галт хэрэглэл /сум/-ийг тусгайлан бэлтгэсэн төмөр сейфэнд галт зэвсэг, дайзнаас тусад нь хадгалж аюулгүй байдлыг бүрэн хангасан. Цагдаагийн газрын даргын тушаалаар галт хэрэглэл /сум/-ийг хариуцах алба хаагчаар нярав-цагдаа, цагдаагийн дэд ахлагч А.Үржинбадамыг томилж, хариуцуулсан.

Зэвсгийн өрөөнд төмөр сейфэнд хадгалж буй галт зэвсгүүдийг дугаарлан соортолж, зэвсгийн өрөөний түлхүүрийг төмөр хайрцагт хийж, нууцлалыг хангаж, зэвсэг хариуцсан албан тушаалтан лацдаж, жижүүрийн шуурхай албанд хадгалуулж, ерөнхий жижүүрүүд зэвсгийн өрөөний лац хүлээн авсан, хүлээлгэн өгсөн бүртгэлээр өдөр тутам хүлээлцэж хэвшсэн.

“Зэвсэг-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд бүртгэл тооллогод хамрагдаагүй галт зэвсгүүдийг нөхөн тоолох чиглэлээр ирүүлсэн мэдээлэл, ажлын чиглэлийн хүрээнд галт зэвсгийн бүртгэл, тооллогод хамрагдаагүй 75 галт зэвсгээс 23 галт зэвсгийг нөхөн тоолж нэгдсэн санд оруулж, бүртгэлтэй галт зэвсгээс эзэмшигчийн хаяг шилжсэн 1 галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хийж, устгуулахаар хүсэлт гаргасан 3 иргэний галт зэвсгийг материалжуулан хураан авч, галт зэвсгийн сангийн хураасан хэсэгт оруулан, нэгдсэн сангаас хасалт хийж ажилласан.

Галт зэвсгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд давхар бүртгэлтэй галт

зэвсгийг тулгалт хийж ажиллахад хоёр өөр эзэмшигчид давхар бүртгэлтэй 2 галт зэвсэг, нэг эзэмшигчид давхар бүртгэлтэй 2 галт зэвсгийн судалгааг тус тус шинэчлэн гаргаж, давхардлыг арилгуулсан.

Галт зэвсэг эзэмшигч нь анх бүртгэгдсэн оршин суух хаягтаа амьдардаггүй, өөр дүүрэг, аймагт шилжсэн, эзэмшигч нас барж тухайн галт зэвсэг хаана байгаа нь тодорхойгүй, хулгайд алдсан, галд шатсан, усанд урсгасан, суваргад хийсэн гэх шалтгаанаар бүртгэл тооллогод хамрагдаагүй 24 галт зэвсгийн судалгааг гарган, нотломжийг галт зэвсгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулан үндсэн жагсаалтаас төлөв өөрчилсөн хэсэгт шилжүүлэн хасаж, нөхөн тооллогын дүн, мэдээг гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд хүргүүлсэн.

#### **Эргүүлийн үйл ажиллагааны чиглэлээр:**

Гудамж талбай, олон нийтийн газруудад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, эргүүл, хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын тушаалаар баталсан “Дүн, шинжилгээ судалгааны баг” 2 удаа хуралдаж, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, цаашид хийх ажлаа тодорхойлон ажиллаж байна.

Судалгааны багийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх дүгнэлт, саналыг үндэслэн Арвайхээр сумын нутаг дэвсгэрт ажиллах эргүүлийн нэгдсэн байршилтыг Цагдаагийн газрын даргын 2022 оны А/73 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулж, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа болон үйлдэгдэж болзошгүй цэгүүдийн ойр орчимд эргүүлийг зохион байгуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналтыг сайжруулан, хэв журмын өдөр, оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэлийг чанаржуулж, алба хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.

Тухайлбал: Жил бүрийн 3 дугаар сард бүх нийтээрээ тэмдэглэх баяр, амралтын өдрүүд их байдагтай холбогдуулан иргэдийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, архины зохисгүй хэрэглээнээс татгалзах, уриалга, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор эргүүл, хяналт шалгалтын чанарт онцгойлон анхаарч тасгуудыг 7 хоног бүрийн Лхагва гаригт бүлгийн эргүүлд татан ажиллуулж хэвшсэн мөн хэсгийн байцаагчид хариуцсан багт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах, багийн цагдаа нар гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг Арвайхээр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт 14.00-19.00 цагийн хооронд бүлгийн эргүүлээр ажиллах хуваарь, төлөвлөгөөний дагуу Арвайхээр сумын багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран ажил, арга хэмжээг зохион байгуулж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангуулан, ажлын хариуцлага, ёс зүйг чанд сахин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагаас биечлэн хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцон ажиллалаа.

Гудамж талбай, олон нийтийн газруудад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, эргүүл, хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах зорилгоор цагдаагийн газрын тасгийн дарга нарт Арвайхээр сумын 13 багийг хариуцуулж, нийт алба хаагчдыг тасгийн дарга нараар ахлуулан багт хуваарилан, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна.

Эргүүлд гарч буй алба хаагчдад хутганаас хамгаалах хантааз, хутганаас хамгаалах бээлийг эргүүлд гарах үед өмсүүлж, тухайн өдрийн жижүүрийн офицер нь хантааз, бээлий, мөн энгэрийн камерыг алба хаагчдад тавьж олгон эргүүлээс буух үед хураан авч аюулгүй байдлыг нь хангуулан хяналт тавьж, нийт алба хаагчид дохиур, шүгэлтэй үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтын

шалтгаан нөхцөл нь иргэдийн дунд архидан согтуурах явдал их байгаатай холбоотой гэж үзэж гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлддэг, үйлдэж болзошгүй, согтуурах, мансуурах донтой иргэдийг судалгаандаа авч дахин гэмт хэрэг, зөрчил үйлдүүлэхгүй байх зорилгоор энэ оны нэгдүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд “Сар шинэ-2023”, “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээг, орон нутгийн хэмжээнд “Хүүхэд хамгаалалд-бидний оролцоо”, “Буудал”, “Эргүүл хяналт”, “Согтуу”, “Судалгаа хяналтын сан” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж, үр дүнг тооцов. Эргүүлийн чиглэлийг хянах зорилгоор “Zenly” апплейкшныг гар утсанд суулгаж, эргүүлийн хугацаанд тасгийн дарга, ахлах байцаагч нараас цахимаар тогтмол хяналт тавин ажиллаж байна. Нэмэлтээр хэсгийн байцаагч, багийн цагдаа нарын хариуцсан багт 7 хоногт 2 удаа эргүүл, шалгалтад ажиллах хуваарийг газрын даргаар батлуулж биелэлт үр дүнд хяналт тавин ажиллаж байна. Шинээр төвийн 13 багийг тасгийн дарга, ахлах албан тушаалтанд хариуцуулж хариуцсан багт судалгаа хийх ажлыг зохион байгуулснаар гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 8.1 хувиар буурсан. Нийт гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 93 нэгжээр буюу 26.6 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

### **Тэсэрч дэлбэрэх бодисын чиглэлээр:**

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт Монгол улсын “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих”, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2011” стандарт, “Аюултай ачаа MNS 4978:2000” стандарт, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулан хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн ажилласан. Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн дагуу Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Багануур дүүрэг, Өмнөговь, Төв зэрэг аймгуудаас Ховд аймгийн Дорви, Хөшөөт, Цэцэг, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Наранмандал, Говь-Алтай аймгийн Цээл, Есөнбулаг, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумд руу ачааны автомашинаар 68 удаа тэсрэх бодис тээвэрлэн Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 76 алба хаагч ажиллаж зөрчил дутагдалгүй дамжин өнгөрүүлсэн байна. Тухайн тэсэлгээний бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслүүд дамжин өнгөрөх тохиолдол бүрийг Арвайхээр сумаас зүүн тийш 15 километрт байрлах Онгийн голын хяналтын постон дээр бүртгэн Цагдаагийн газарт мэдэгдсэнээр хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчид журмын дагуу хөтөч машинтай хамгаалалтын үүрэг гүйцэтгэн нэвтрүүлж мэдээллийг дор бүрд нь холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Тэсрэх бодис болон тэсэлгээний материал тээвэрлэн явж байгаа тээврийн хэрэгслийн жолооч нараас зөрчил заагдсан хүн байхгүй байна.

### **1.6. ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСАГ**

Цагдаагийн байгууллагад иргэдээс ирүүлсэн дуудлага мэдээллийг бүрэн хүлээн авч хяналт тавих үйл ажиллагааны чиглэлээр 2022 оны 02 дугаар улиралд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2071 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс гэмт хэргийн 336 зөрчлийн 1735 дуудлага, мэдээллийг 100 хувь бүртгэж хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Тасгийн даргаас гэмт хэрэг зөрчлийн 1713 дуудлага мэдээлэлд, жижүүрийн ахлах мөрдөгчөөс гэмт хэрэг, зөрчлийн 358 дуудлага мэдээлэл, зөрчлийн хэрэг бүртгэгч нарын 1215 материалд хяналт тавьж, ажилласан. Цагдаагийн газарт иргэд байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээллийг нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдсэн талаарх мэдээллийг иргэний гар утсанд “Мессеж” хэлбэрээр хариуг мэдэгдэж байна.

Байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж

удирдлагыг мэдээллээр хангах үйл ажиллагааны чиглэлээр “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх” /код 201/ журамд заасны дагуу гэмт хэргийн мэдээллийг цагдаагийн газрын дарга, ЦЕГ-ын Мэдээлэл шуурхай удирдлагын төвд зөрчил дутагдалгүй тухай бүр мэдээлсэн. Жижүүрийн бүрэлдэхүүн томилгоот алба хаагчийг мэргэжлийн удирдлагаар хангаж гэмт хэргийн талаарх мэдээллийг шуурхай зарлан мэдээлэх эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулсны үр дүнд гэмт хэргийг халуун мөрөөр нь 41 гэмт хэргийг илрүүлсэн. Шуурхай удирдлагын тасгийн алба хаагчдаас нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээлэл олж баримтжуулан 4 илтгэх хуудас бичиж, 2 илтгэх хуудас батлагдан шалгагдсан.

Дуудлага мэдээллийн шийдвэрлэлт ECS программын ашиглалтад хяналт тавих үйл ажиллагааны чиглэлээр иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, дуудлага мэдээлэл бүрийг жижүүрийн 7032102 дугаарын тусгай дугаарт 2 шугамаар хүлээн хүлээн авч, гомдол мэдээллийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-200/ журамд заасны дагуу 100 хувь бүртгэн “ECS” системд болон хоногийн нөхцөл байдлын программд зөрчил дутагдалгүй шивж оруулахад хяналтыг тогтмол тавьж, зөрчил дутагдалгүй ажилласан.

Мөн дуудлага мэдээллийн “ECS Mobile tablet” программ шинэчлэгдэж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийн холбогдогч, хохирогчийг регистрийн дугаараар нь бүртгэх таблетад шинээр 80442978 дугаарыг авч, Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх авахаар хүсэлтийг хүргүүлсэн. Энэхүү программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн.

ЦБҮАЖ /код-200/ “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа”, /код-201/ Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх, /код-202/ “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах” журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн тусгай дугаарын 7032102, 70327102 утсаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлж буй гэмт хэрэг, зөрчил, гамшиг, осол, гал түймрийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх дуудлага, онцлох мэдээллийг тухай бүр хүлээн авч, цагдаагийн газрын удирдлага, ЦЕГ-ын ерөнхий штаб, ерөнхий зохицуулагч нарт шуурхай дамжуулан холбогдох алба хаагч нарт хуваарилж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан.

### **Гурав. Холбоо мэдээлэл, технологийн талаар:**

Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдлага алба, нэгжээс зохион байгуулсан нийт 144, 19 сумдын хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгчидтэй нийт 132 удаагийн цахим хурал, сургалтын үеэр дуу, дүрсний техник, хэрэгслүүдийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Холбооны техник хэрэгсэлд засвар, үзлэг үйлчилгээ хийх график хуваарийн дагуу сумдын хэлтэс, тасгийн алба хаагчдаас засвар үйлчилгээ хийлгэхээр ирүүлсэн хэт богино долгионы гар станц 56, авто машин станц 17, суурин станц, тусгай дуут гэрэл дохио 6, дахин дамжуулах станц 1, бэлэн бус торгуулийн төхөөрөмж-38, түүний дагалдах хэрэгсэл принтер 33, компьютер-102, түүний дагалдах хэрэгсэл принтер-37, автомат телефон утас-15, бичлэгийн болон сүлжээний төхөөрөмж-10, энгэрийн камер-56, эрүүлжүүлэх баривчлах саатуулах байрны теле хяналтын камер-14, бусад техник хэрэгсэлд засвар, үзлэг үйлчилгээг хийсэн.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын камер-27, байцаалтын өрөөнүүдийн камер-8, дуудлага мэдээлэл хүлээх авах жижүүрийн өрөөний камер-1 нийт 50 ширхэг IP камерын хэвийн ажиллагааг ханган сар бүр задлахгүйгээр техникийн үзлэг үйлчилгээг нийт 6 удаа, байгууллагын аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын теле хяналтын камер, сүлжээний төхөөрөмжүүд, swich, router, программ, бусад техник хэрэгсэлд техникийн үзлэг, үйлчилгээг хийх хуваарь, график гаргаж нийт 418 ширхэг, 7 төрлийн техник хэрэгслийн техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ хийж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг

хангаж ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагч нарт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-114.11.3/-д “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад заасан мэдээлэл, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл, хэрэг бүртгэлд, мөрдөн байцаалтын хэргийн материал, баримт бичгийг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнээс бусад цахим сүлжээ үүсгэн ашиглаж, аливаа хэлбэрээр /Bluetooth гэх мэт/ алба хаагч нар хоорондоо болон бусдад дамжуулан, хадгалах /гар утас, зөөврийн төхөөрөмжид файл үүсгэх/-ийг хориглоно.” гэж заасан.

Холбогдох мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөмж өгч, Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбогдсон албаны компьютерт “VPN” ашиглан бусад интернэт сайт руу хандалт хийхгүй байх, цагдаагийн байгууллагын сүлжээний аюулгүй байдлыг алдагдуулах ноцтой зөрчил гаргахгүй байх талаар зөвлөгөө өгч, хяналт тавьж ажилласан.

### **Дөрөв. Мэдээлэл судалгааны сангийн маягт бүрдүүлэлтийн талаар:**

Тус газрын мэдээллийн нэгдсэн санд энэ оны хагас жилд нийт 42.441 маягт бүрдүүлснээс гэмт хэргийн тоо бүртгэлийн санд 2222, зөрчлийн тоо бүртгэлийн санд 135 маягт, Зөрчлийн санд 4848, /маягт-3100/-д 32131 маягтаар тус тус баяжилт хийгдсэн. Мэдээллийн сангийн маягт бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр энэ оны 01 дүгээр улиралд мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтнээс санд ажиллах эрх бүхий алба хаагч нарт хэсэгчилсэн сургалтуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 7 удаа орсон нь алба хаагчдын санд ажиллах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн үр дүн гарсан. Мөн маягт бүрдүүлэлтэд тавих хяналтыг тогтмолжуулж 7 хоног бүр Цагдаагийн газрын даргад танилцуулж, зөрчлийг тухай бүр засуулж, дахин зөрчил гаргахаас урьдчилан сануулснаар мэдээллийн санд гарч буй алдаа дутагдал эрс багсаж, төвөөс заагдах зөрчил байхгүй болсон нь сайшаалтай байна.

Цагдаагийн газрын нээлттэй пэйж хуудасны чат хэсэгт нь ЧАТ-БОТ үйлчилгээг нэвтрүүлж сар бүр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг байршуулж, мэдээлэл хийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Сар бүр харьцуулсан болон сумдад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээг гаргаж сумдын ИТХ-ын дарга, хэсгийн төлөөлөгч нарт нийт 14 судалгаа гаргаж хүргүүлэн ажиллав. Шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг, зөрчлийн санд гарч байгаа мэдээ, мэдээллийн чиглэлээр шууд лайв хийж албан хаагчдын ойлгохгүй байгаа асуудалд тухай бүр тайлбарыг хийж, асуудлыг шийдвэрлэн ажиллав.

Байгууллагын нээлттэй хуудсаар Өвөрхангай аймгийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээллийг сар тутам иргэд, олон нийтэд ил тод байршуулж, 7 хоног тутам байгууллагын нээлттэй пэйж хуудсанд 7 хоногийн нөхцөл байдлыг байршуулан иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр ханган, ажилласан.

Мэдээлэл, дүн шинжилгээ, Шуурхай удирдлагын албанаас энэ оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс зохион байгуулах “Системийн динамик загвар (Vensim)”, “Arcgis” программ хангамжийг дүн шинжилгээ, судалгааны багуудад нэвтрүүлэх зорилгоор танхим болон цахим сургалтад хамруулахаар 6 алба хаагчийн нэрийг хүргүүлж, дээрх сургалтад хуваарийн дагуу хамруулсан. Хариуцсан орон нутгийн хэмжээнд “Системийн динамик загвар (Vensim)”, “Arcgis” программ хангамжийг ашиглах чиглэлээр санаачилга гарган ажиллаж байна.

### **2.7. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ ТАСАГ**

2023 оны эхний хагас жилийн байдлаар тус цагдаагийн газарт зөрчлийн шинжтэй нийт 2757 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс зөрчлийн хэрэг 2440 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 101 нэгжээр буюу 4.0 хувиар буурсан. Зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн зөрчил 81 байгаа нь урьд оны мөн үеэс 16 буюу 19.8 нэгжээр буурсан. Хялбаршуулсан журмаар 1524 зөрчлийг 238.800.000 төгрөгөөр торгож, хялбаршуулсан журмаар шалгаж

шийдвэрлэсэн нь 211 нэгжээр буюу 12.2 хувиар буурсан. Ердийн журмаар 138 зөрчлийг 19.510.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн нь 27 буюу 24.3 хувиар өссөн. Зөрчлийн хэрэгт 534 хүн баривчилсан нь өмнө оны мөн үеэс 23 буюу 4.5 хувь өссөн. Энэ онд 471 зөрчилд торгож, эрх хассан нь 43 буюу 8.4 хувь буурсан. Мөн Засгийн газрын 2017 оны 195, 196 дугаар тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын хэрэгжилтийг хангаж зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдад өгөх үүрэг чиглэлийг боловсруулан газрын даргаар батлуулан энэ оны 01 дүгээр сарын 02 өдрийн 01 дүгээр үүргийн хуудсыг алба хаагчдад хүргүүлэн улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдөр нэгтгэн дүгнэж ажиллаж байна.

## **ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН**

### **2.1 Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр танилцуулга**

Аймгийн хэмжээнд энэ оны эхний 06 сард 324.8 сая төгрөгийн хохиролтой, 128 холбогдогчтой, эрүүгийн 214 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад -32.1 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлт 38.9 хувьтай байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад +6.3 хувиар өссөн байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж, танилцуулгыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 4, аймаг, сумын Засаг дарга 4, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 4 удаа тус тус хүргүүлсэн.

**2.2 ГХУС ажилд зарцуулсан хөрөнгө** Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл энэ оны төсөвт нийт 127.000.000 /нэг зуун хорин долоон сая төгрөг/-ийг төсөвлөсөн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажлын хэсгээс Чингэлтэй дүүргийн “Ногоон бүс”-тэй танилцах, туршлага судлах, сургалтад хамрагдах зардалд 1.491.550 төгрөг, хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 900.000 төгрөг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц наркологийн тасгаас Архидан согтуурахтай тэмцэх “Өөртөө туслах” төвд ирж сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтын зардал 600,000 төгрөг, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах орчин үеийн чиг хандлага сургалтын зардал /хоол/ 162,000 төгрөг, Өвөрхангай мэдээ сонинтой хамтран ажиллах гэрээ 3,000,000 төгрөг, “Шилдэг мөрдөгч-2023” /албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх/ шалгаруулах тэмцээний 1,200,000 төгрөг, “Таниулья, мэдээлье, илрүүлье” хэлэлцүүлэг 910,000 төгрөг, “Эко клубүүдийн чуулга уулзалт” 940,000 төгрөг, Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдад хууль сурталчлах чиглэлээр ажилласан зардал 3,750,000 төгрөг, “Өөртөө туслах” бүлгийн сургагч багшийн сургалтын зардал 600.000 төгрөг, Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн шторк 10 ширхэг 3.000.000 төгрөг, “Камержуулалт-IV” аяны шторк, гарын авлага 1.000.000 төгрөг, Шуурхай удирдлагын төвийн камерын арчилгааны зардал 2.000.000 төгрөг нийт 19,553,500 төгрөгийг тус тус зарцуулсан.

Баян-Өндөр сумын хэсгийн төлөөлөгчийн албан ажлын хэрэгцээнд энэ оны 03 дугаар сард Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 19.5 сая төгрөгөөр Toyota Succeed маркын, Бүрд сумын хэсгийн төлөөлөгчийн албан ажлын хэрэгцээнд энэ оны 04 дүгээр сард Засаг даргын тамгын газрын орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгөөр Toyota Probox маркын автомашиныг тус тус авч өгөн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Өлзийт сумын Цагдаагийн хэсгийн алба хаагчдад сумын Засаг даргын тамгын газраас албаны үйл ажиллагаанд ашиглах иж бүрэн суурин компьютер, өнгөт принтер шийдвэрлэж өгсөн.

### **2.3 Цагдаагийн байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, зааварчилга**

Цагдаагийн газрын дарга, удирдлагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тушаал 1, үүрэг 1, зөвлөмж 4, шаардлага 24, нийт 30 албан бичгийг сумдын хэлтэс, тасаг, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчид хүргүүлсэн.

Агуулгаар нь харуулбал:

ЦЕГ-ын даргын 2022 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-721/ Дүн шинжилгээ, судалгаа хийх журмын дагуу байгууллагын “Дүн шинжилгээ судалгааны багийг 5 удаа хуралдуулж, 2022 он, 2023 оны 01, 02 дугаар сард тус аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар цагдаагийн газрын даргад танилцуулан судалгааны багаас 2023 онд хийж гүйцэтгэх ажлын 49 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус аймгийн гэмт хэрэг, зөрчлийн 14 хоног тутмын нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх санал, танилцуулгыг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны, Дүн, шинжилгээ судалгааны хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн газрын даргаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон үйлдэж болзошгүй этгээд, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 12 дугаартай үүргийг холбогдох алба хаагч нарт хүргүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтийг тооцон ажилласан.

“Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр энэ оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 41/478 дугаар зөвлөмж, “Хүүхдийн эрх зөрчигдөж, аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх” чиглэлээр энэ оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 41/806 дугаар зөвлөмж, Дүн шинжилгээ, судалгааны багаас 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр зөвлөмж, 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар зөвлөмж, Төгсөлт арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын 2022-2023 оны хичээлийн жилийн “Эрдмийн баяр” болохтой холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлага хүргүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

**Гурав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийг хэрэгжүүлэх талаар. /ГХЗУСТХ-ийн 8-р зүйл/, /ЦАТХ-ийн 64-р зүйл/**

**3.1 Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ** Энэ оны 1 дүгээр сард орон нутгийн хэмжээнд “Буудал” хэсэгчилсэн арга хэмжээ, “Хүүхэд хамгаалалд-бидний оролцоо” нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулан, 9 удаагийн хяналт, шалгалт, урьдчилан сэргийлэх эргүүлийн ажлыг зохион байгуулан иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг нэмэгдүүлэв.Үүнд:

1.1. Хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, далд хэлбэрт үйлдэгдэх хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Буудал” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгуулав. Аймгийн хэмжээнд 24 буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас Арвайхээр 15, Хархорин 5, Бат-Өлзий 2, Баянгол, Уянга сумдад тус бүр 1 байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн бүртгэлийн “Объект” хэсэгт 18 зочид буудлын мэдээллийг шивж оруулсан. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр 8 албан мэдэгдэл хүргүүлэн.

Шалгалтын явцад насанд хүрээгүй 1 иргэнийг асран хамгаалагчгүй оруулсан байсныг Шүүх шинжилгээний албаны шинжээч эмчийн үзлэгт хамруулахад, хохирсон байдал тогтоогдоогүй.

“Тухайн иргэнийг Судалгаа хяналтын сан-”гийн нэцэг, эхийн хараа хяналт сул хүүхдийн бүртгэлд мэдээллийг бүртгэн, ар гэр, асран хамгаалагчийг дуудаж

хүлээлгэн өгсөн.

1.2. "Хүүхэд хамгаалалд-бидний оролцоо" нэгдсэн арга хэмжээг 5 байгууллагыг оролцуулан зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд насанд хүрээгүй иргэдийг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хүүхдэд аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, цахим донтолт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалтын байгууллага, сурагчдын дотуур байрны дээврийн хэсгийн хаалга, гарцын аюулгүй байдлыг бүрдүүлэх, телехяналтын камерын ашиглалт, сургууль орчмын аюулгүй байдлыг сайжруулахад хяналт тавих, зөвлөн туслах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Хүүхэд хамгаалалд - бидний оролцоо" нэгдсэн арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж байна.

Арвайхээр сумын сургуулийн өмнөх боловсролын 4 дүгээр цэцэрлэгийн ахлах бүлгийн 40 хүүхдэд "Хэрхэн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох вэ?", Алтан гадас одонт ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 90 сурагчдад "Замын хөдөлгөөний дүрэм", 8-9 дүгээр ангийн 410 сурагчдад "Мэргэжил сонголт, дотоод хэргийн их сургуульд элсэх нь", "Гэмт хэрэг зөрчлийн талаарх ойлголт" сэдвээр, "Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч нарт явганаар замын хөдөлгөөнд оролцох үеийн аюулгүй байдал хангагдсан эсэх талаарх эрсдэлийн үнэлгээг гарган дотуур байранд амьдардаг 53 сурагчид "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль", "Зөрчлийн тухай хууль"-иар, Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 7-12 дугаар ангийн 65 сурагчдад, Арвайхээр сумын сургуулийн өмнөх боловсролын 1 дүгээр цэцэрлэгийн 56 эцэг эхчүүд, баривчлагдсан саатуулагдсан 82 иргэнд "Эцэг, эхийн үүрэг хариуцлага", "Гэр бүлийн хүчирхийлэл" сэдвээр тус тус 12 удаа 13 цагийн сургалтыг нийт 934 иргэнд зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэв.

Бага насны хүүхдүүдийг ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 төрлийн зурагт хуудас, мөн Боловсролын ерөнхий газраас бэлтгэсэн цагаан сар 5 зөвлөмж, Нийслэлийн цагдаагийн газрын удирдах газраас бэлтгэсэн 1 төрлийн зөвлөмжийг цагдаагийн газрын цахим хуудаст байршуулан иргэд олон нийтэд, хүүхдийг дэлгэцийн донтолт, цахим орчин дахь гэмт хэрэг хүчирхийлэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх 1 төрлийн зурагт хуудас бэлтгэж цагдаагийн газрын цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтэд хүргэж ажиллав.

Арга хэмжээний хүрээнд осол гэмтэл, болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 8 ширхэг зурагт хуудас бэлтгэн цагдаагийн газрын цахим хуудаст байршуулан, иргэд олон нийтэд хүргэж, аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын болон улсын чанартай авто замуудад цагийн менежментээр үүрэг гүйцэтгэж буй 7 сум, 24 цагийн үүрэг гүйцэтгэдэг /Хархорин, Нарийнтээл, Онгийн голын/ хяналтын 3 пост, өдөр, орой, эргүүлд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид 5 төрлийн хэвлэмэл хуудас 17063 ширхгийг тараав.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 57 дугаар тогтоолоор хориглосон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор "Арвагар хээр" морин спорт уяачдын холбооны гүйцэтгэх захиралд энэ оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн г/09 дугаар албан мэдэгдлийг хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын энэ оны А/25 захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган, иргэд олон нийтэд таниулахаар зурагт хуудас бэлтгэн цагдаагийн газрын нээлттэй цахим хуудсаар 151 удаа түгээлт хийж хүргэсэн байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газартай хамтран эргүүл хийх хуваарийн дагуу 8 удаа амралтын өдрүүдэд Дэлгэрэх, Дайраг, Онгийн гол дагуу агаарт гарч мөсөн дээр болон машинаар хүүхдүүдийг чирж гулгуулж байгаа 126 иргэдэд урьдчилан сэргийлэх чиглэлээр



мэдээлэл, санамж, зөвлөмж өгч ажилласны үр дүнд хүүхэд осол, гэмтэлд өртөөгүй байна.

Осол гэмтэл, болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 8 ширхэг зурагт хуудас бэлтгэн цагдаагийн газрын цахим хуудаст байршуулж иргэд олон нийтэд хүргэж, 5 төрлийн хэвлэмэл хуудас 17063 ширхгийг тараан, 12 удаа 934 иргэдэд сургалт зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэв.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 24 буудалд хяналт шалгалт зохион байгуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр 8 албан мэдэгдэл хүргүүлэн 1 албан мэдэгдлийн хариуг авч тооцон, Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн бүртгэлийн “Объект” хэсэгт 18 зочид буудлын мэдээллийг шивж оруулсан.

1.3. Хулгайн болон гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 7 удаа зохион байгуулж, 460 ширхгийг тараав.

1.4. Сар шинийн баяр, амралтын өдрүүдээр иргэдийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор эргүүл, хяналт шалгалтын чанарт онцгойлон анхаарч, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран сумдад “Олон нийтийн эргүүл”-төрийн байгууллагуудын алба хаагчдыг татан ажиллууллаа.

Дээрх урьдчилан сэргийлэх ажилд төрийн 35, аж ахуйн нэгж байгууллагын 297 ажилтан, алба хаагч, малчдын бүлэг 19, хөршийн хяналтын бүлэг 21, хамтарсан баг 26 нийт 1118 гишүүнийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган цагдаагийн алба хаагчдын хамт үүрэг гүйцэтгэж ажилласан.

Энэхүү урьдчилан сэргийлэх ажилд Арвайхээр сумын урамшуулалт 12 олон нийтийн эргүүл, цагдаагийн алба хаагчтай хамтран урьдчилан сэргийлэх тээврийн хэрэгсэл, халаасны болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг гудамж талбай, зах худалдааны төвүүдийн ойр орчмоор тарааж, сэрэмжлүүлэг яриа таниулга хийв.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага, архи, согтууруулах ундааны зүйлээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүд, хүнсний дэлгүүр, бөөний төвүүдэд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрлийн мэдэгдлийг 25 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Золголтоор хөдөө орон нутагт зорчих иргэд, хүүхдийн аюулгүй байдлыг ханган, зориулалтын суудалд болон хамгаалах бүс зүүлгэж тээвэрлэх, гарц, гарамтай газраар зорчих, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хөдөлгөөнд оролцох зэргээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 5 төрлийн анхааруулга, сэрэмжлүүлгийг хөдөлгөөнд оролцож байгаа 3500 жолоочид хүргэн ажиллав.

2. “Сар шинэ-2023” нэгдсэн арга хэмжээний хүрээнд гудамж, зам талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулахаар найман чиглэлд уртасгасан цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласнаар 23 гэмт хэргийг илрүүлэн яллагдагчаар татсан байна.

3. Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон үйлдэж болзошгүй этгээд болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байхад хяналт тавих зорилгоор “Судалгаа хяналтын сангийн баяжилт” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 2 сарын хугацаатай зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 220 иргэний судалгааг шинэчлэн гарган, судалгаа хяналтын санд шинээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 410 иргэн, хүүхдийн нэгдсэн бүртгэлд

427 хүүхдийн мэдээллийг тус тус шивж оруулан, хяналт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар 49 иргэдийн гэрээр орж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч нартай уулзан бүртгэл хөтлөн, зөвлөгөө, зөвлөмж, яриа таниулга хийж, мэдээллийг санд шивж оруулсан.

4. “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд 6 постер бэлтгэн, байгууллагын цахим хуудаст байршуулан, иргэд, олон нийтэд сурталчилж, Хүний эрхийн комиссын Өвөрхангай аймаг дахь салбарын ажилтан, жендерийн сургагч багш М.Ичинхорлоо “Жендерийн үндсэн ойлголт” сэдвээр сургалт орж, 113 алба хаагч хамрагдаж, Жендерийн үндэсний хорооноос гаргасан 2 видео шторк, 18 төрлийн зурагт хуудсыг байгууллагын цахим хуудаст байршуулан, иргэд, олон нийтэд сурталчилж ажиллав.

5. Насанд хүрээгүй хүнд үйлчилж, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт татан оролцуулж байгаа эсэхэд хяналт тавих, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, далд хэлбэрт үйлдэгдэх хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Буудал” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгуулав. Аймгийн хэмжээнд 24 буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас Арвайхээр 15, Хархорин 5, Бат-Өлзий 2, Баянгол, Уянга суманд тус бүр 1 байна. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн бүртгэлийн “Объект” хэсэгт 18 зочид буудлын мэдээллийг шивж оруулсан. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр 8 албан мэдэгдэл хүргүүлэн, шалгалтын явцад насанд хүрээгүй 1 иргэнийг асран хамгаалагчгүй оруулсан байсныг Шүүх шинжилгээний албаны шинжээч эмчид үзүүлэхэд бэлгийн харьцаанд ороогүй байсан.

6. Нийслэлийн цагдаагийн удирдах газраас “Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд өсвөр насныханд зориулж “Чи ганцаараа биш” нөлөөллийн аяны хүрээнд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын пэйж дээр орсон мэдээллийг алба хаагчдаар түгээлгэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, байгууллагаас 5 төрлийн зурагт хуудас гарган сурталчлах ажлыг хийж байна.

7. “Нуугдмал” арга хэмжээний хүрээнд салбар төлөвлөгөөг гарган, хэлтэс тасгуудад хүргүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 11-ний өдөр төрийн байгууллагуудтай хамтран “Таниулъя, мэдээлье, илрүүлье” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн насанд хүрээгүй хүн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 1 гэмт хэргийг илрүүлэн, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 131 иргэн, 76 аж ахуй нэгж, байгууллага, хамтарсан баг, сургуулийн эргүүл, малчдын бүлэг, нөхөрлөл, хөршийн хяналтын бүлэг, өсвөрийн сэргийлэгч бүлгэм зэрэг нийт давхардсан тоогоор 4277 иргэнийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж хамтран ажилласан.

8. Энэ оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Анхаарч хамгаалъя” аяныг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 75 хоногийн хугацаатай зохион байгуулж, нээлтийн арга хэмжээнд “Хүүхдийн эрх, бэлгийн халдашгүй байдал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээх хариуцлага”, “Гэр бүлийн хүчирхийллийн сүүлийн 5 жилийн тоон мэдээлэл” зэрэг сэдвээр сургалт, мэдээлэл хийж, нийт 87 иргэн хамрагдсан.

9. Гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Прокурорын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран насанд хүрээгүй хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад албан тушаалтны үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, далд хэлбэрт үйлдэгдсэн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр “Таниулъя,

мэдээлье, илрүүлье” уулзалт, хэлэлцүүлгийг энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Хүүхдийн Ордны “Орхон” кино театрт зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн 32 байгууллагын 130 ажилтан, алба хаагч, иргэд оролцсон. Хэлэлцүүлгийн явцад төрийн ажилтан, алба хаагч болон иргэдээс нэлээдгүй санал гаргаж, саналыг нэгтгэж, 3 заалт бүхий уриалга, зөвлөмжийг гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

10. “Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолоор хориглосон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор “Арвагар хээр” морин спорт уяачдын холбооны гүйцэтгэх захиралд энэ оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн г/09 дугаар албан мэдэгдлийг хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын энэ оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/25 захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг иргэд олон нийтэд таниулахаар зурагт хуудас бэлтгэн цагдаагийн газрын нээлттэй цахим хуудсаар 151 удаа түгээлт хийж хүргэсэн байна.

Мөн судалгаа хяналтын санд шинээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 423 иргэн, эрсдэлт нөхцөлд байгаа 456 хүүхдийн мэдээллийг шивж оруулан, хяналт тавин ажиллаж байна. Хархорин сумын “Солонго” асрамж, халамжийн төвийн үйл ажиллагаанд тус сумын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнээс хяналт тавин, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тус төвд 5-19 насны 14 хүүхэд /үүнээс цэцэрлэгт 1, албан бус сургалтад хамрагдаж байгаа 1, Ерөнхий боловсролын сургуульд 12/ хүмүүжиж байна. Тухайн сурагчдад 1 удаа “Хүүхдийн эрхийн тухай ойлголт” сэдвээр 1 цагийн сургалтыг зохион байгуулан ярилцлага хийж, сонирхсон асуултад хариулт өгч ажиллав.

11. Өвөрхангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан 05 дугаартай “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад ажиллах” удирдамжийн дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багийн ажлыг арга зүйгээр ханган чадавхжуулж, шалган, зөвлөн туслах, сумдын иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор энэ оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдад ажилласан.

Ажиллах хугацаанд хамтарсан багийн гишүүд болон хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн төрийн алба хаагч, эцэг, эхчүүдэд “Нэгдүгээрт хүүхэд”, “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлага”, “Хүчирхийллийг үл тэвчих, нийгмийн эерэг сэтгэл зүй, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх”, “Нийгмийн стрессийг нийлж засъя”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, бага, дунд, ахлах ангийн сурагчдад “Хүрэхүйн тухай ойлголт”, “Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Электрон тамхины хор нөлөө”, “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдвээр тус тус сургалтыг зохион байгуулж, нийт 1419 иргэнийг хамруулж, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллав.

Энэ оны эхний 5 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, бусад чиглэлээр 168 удаагийн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэн 7889, хүүхэд 3837 хамрагдаж, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллав.

Энэхүү урьдчилан сэргийлэх ажилд Арвайхээр сумын урамшуулалт 12 олон нийтийн эргүүл, цагдаагийн алба хаагчтай хамтран урьдчилан сэргийлэх тээврийн хэрэгсэл, халаасны болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх зурагт хуудсыг гудамж талбай, зах худалдааны төвүүдийн ойр орчмоор тарааж, сэрэмжлүүлэг яриа таниулга хийв.

12. Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, бригадын генерал Ц.Ням-Очир нарын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хамтран баталсан “Хүн бүр байгаль хамгаалагч” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах салбар төлөвлөгөөг гарган, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн даргаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд:

Цагдаагийн газрын нээлттэй фэйсбүүк хуудасны болон алба хаагчдын өөрсдийн фэйсбүүк хаягийг алба хаагч тус бүрээр “Хүн бүр байгаль хамгаалагч” ковер зургаар солиулж, уг аянд нэгдсэн.

Байгальд ээлтэй хандлага, зөв дадал, шийдлүүдийг танилцуулах, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар орон нутагт тулгамдаж буй асуудал, зорилтыг хангахад байгаль хамгаалах клубүүдийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх, туршлага солилцох, хүүхэд залуусын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, сурагчдын идэвх санаачилгыг өрнүүлэх, өсвөрийн байгаль хамгаалагчдыг бэлтгэх зорилгоор “Эко клубуудын чуулга уулзалт”-ыг аймгийн БОАЖГазар, ГХУСАЗСЗ-ийн “Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-тэй хамтран энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан.

Уг чуулга уулзалтад аймгийн 19 сумын Ерөнхий боловсролын 30 сургуулийн эко клубүүд, байгальд ээлтэй ангийн 220 сурагч оролцож, байгаль орчныг хамгаалах, экологийн боловсрол олгох, туршлага, мэдээлэл солилцож, “Хүн бүр байгаль хамгаалагч аян”-д нэгдсэн.

Арга хэмжээний хүрээнд Экологийн цагдаагийн албаны пэйж хуудсанд байршуулсан контент, постеруудыг тус газрын нээлттэй пэйж хуудсанд байршуулж, алба хаагчдаар олон дагагчтай фэйсбүүк хаягт түгээх ажлыг зохион байгуулж, 61900 удаа шэйр хийж, 3229 удаа лайк дарж, 693791 удаагийн хандалт авсан байна.

“Хүн бүр байгаль хамгаалагч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд контент 17, постер 13 бэлтгэн хийж, 8 контент, 2 постер тэнцэж, Экологийн цагдаагийн албанаас 7 од авч, орон нутгийн “uv.live.mn” сайтад 1 удаа шууд ярилцлага мэдээлэл өгч идэвх санаачилгатай ажилласан.

Хүрээлэн байгаа орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах ажилд иргэн бүр идэвх санаачилгатай оролцох соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Дөрвөн-Эрдэнэ” студитэй хамтран аймгийн Ганданпунциглон хийдийн хамба лам Я.Ганзаяа, Монгол Улсын тод манлай уяач Б.Отгоннасан нараар “Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, иргэн бүр байгаль хамгаалагч байх” талаар мэдээлэл, ярилцлага авч, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх контент бэлтгэж, “Хүн бүр байгаль хамгаалагч” гарын авлагыг 800 ширхэг бэлтгэж, хот хоорондын замаар дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарт тарааж, тус аянд нэгдүүлэх арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

Арвайхээр сумын идэвхтэн байгаль хамгаалагч Г.Сүхбаатартай хамтран “Хүн бүр байгаль хамгаалагч” байх талаар 10 постер бэлтгэж, аймгийн олон хандалттай группуудээр түгээлт хийж ажилласан.

Экологийн цагдаагийн албаны цахим хаягт байршуулсан 20 контентыг Арвайхээр сумын нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулдаг “Номин”, “Арина,” “Некст электроникс” худалдааны төвүүдэд худалдаалагдаж буй зурагт, дэлгэцүүдэд болон

төрийн байгууллагуудын хүлээлгийн танхимын дэлгэцүүдэд байршуулан иргэдэд түгээх ажлыг хүртээмжтэй зохион байгуулсан.

Экологийн цагдаагийн албаны пэйж хуудсанд байршуулсан контентуудыг олны танил хүмүүсээс болох МУСТА Б.Идэржавхлан, Э.Чулуунчимэг, Б.Батцэцэглэн, Хөтлөгч дуучин Б.Ууганбаяр, Монгол улсын харцага Ц.Бямба-Отгон, Б.Цэдэнсодном, Монгол Улсын начин Б.Сангисүрэн, Б.Лхагвадорж, аймгийн хурц арслан О.Наранбаатар Үнэн ба зөв намын дарга А.Отгонбаатар нараар шэйрлүүлж “Хүн бүр байгаль хамгаалагч” аянд нэгдүүлэн, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

13. Аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Арвагар хээр морин спорт уяачдын холбоо хамтран “Уралдаанч хүүхдээ анхаарч хамгаалъя” нэгдсэн зөвлөгөөн энэ оны 05 дугаар сарын 05-ны өдөр Хүүхдийн ордон Орхон кино театрт зохион байгуулагдаж, зөвлөгөөнд амжилттай хамтран оролцсон.

Зөвлөгөөнийг нээж аймгийн Засаг дарга А.Ишдорж хэлсэн үгэндээ “Нэгдүгээрт хүүхэд” гэдгийг онцолж, хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг үзэглэв.

Уг зөвлөгөөнийг зохион байгуулснаар Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, эцэг эх, уяачдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг сайжруулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах өндөр ач холбогдолтой юм.

“Хүүхэд хамгаалал”, “Бүртгэл”, “Анхаарч хамгаалъя”, “Хамтдаа хамгаалъя” аян, арга хэмжээний хүрээнд хүүхэд өсвөр үеийнхний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, тэдний өмнө тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд хүүхдүүдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор “Эергээр манлайлъя” хүүхдийн чуулга уулзалтыг Арвайхээр сумын 6 сургууль, Политехникийн коллежийн хүүхдийн өөрөө удирдах байгууллагын болон өсвөрийн сэргийлэгч нийт 150 хүүхэд оролцсон бөгөөд “Хүүхдийн эрх, хамгаалал, хорт зуршил, электрон тамхины хор хөнөөл, цахим орчинд өөрийгөө хамгаалах нь” сэдвээр сургалт, мэдээлэл хийж, сурагчдын сонирхсон асуултад хариулт өгч, харилцан ярилцаж ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх ажилд 155 төрийн болон төрийн бус байгууллага, 50 аж ахуйн нэгж байгууллагын 356 ажилтан, алба хаагч, малчдын бүлэг 15, хөршийн хяналтын бүлэг 16, хамтарсан баг 18 нийт 7834 гишүүнийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган цагдаагийн алба хаагчдын хамт үүрэг гүйцэтгэж ажилласан.

Энэхүү урьдчилан сэргийлэх ажилд Арвайхээр сумын урамшуулалт 12 олон нийтийн эргүүл, цагдаагийн алба хаагчтай хамтран урьдчилан сэргийлэх тээврийн хэрэгсэл, халаасны болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг гудамж талбай, зах худалдааны төвүүдийн ойр орчмоор тарааж, сэрэмжлүүлэг яриа таниулга хийв.

### **3.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулсан ажлын талаар**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөө болон алба хаагчдын харилцаа хандлага, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг энэ оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Уулзалтын үеэр 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, сэтгүүлч нараас асуусан асуултад хариулт өгч, санал солилцон 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөг үзэглэв.

Уулзалтад 4 телевиз, 1 сайт, 2 сонин, сэтгүүл, 1 FM радио, Засаг даргын тамгын газрын хэвлэл, мэдээллийн ажилтан болон Монцамэ агентлаг, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Өвөрхангай аймаг дахь салбарын сэтгүүлч нарын төлөөлөл оролцов.

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн 9 байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах асуудлыг тусгах, хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг хориглосон заалтад хяналт тавьж ажиллаа.

Энэ хугацаанд тухайн заалтыг зөрчсөн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага байхгүй болно.

Цагдаагийн газрын дарга сумдын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч нартай 2023 онд хамтран ажиллах “Гуравласан гэрээ”-г байгуулав.

Уг гэрээг байгуулснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө сайжирч, 2021-2024 онд хэрэгжсэн "Амар тайван-Өвөрхангай", "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиуд болон бусад хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах орчин нөхцөл, албаны унаа, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, улмаар иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг сайжруулахад үр дүн гарч байгаа юм.

Цагдаагийн газрын дарга, Арвайхээр сумдын Засаг дарга, хэсгийн байцаагч нартай 2023 онд хамтран ажиллах гуравласан гэрээ байгуулав.

Тухайн гэрээг байгуулснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө сайжирч, "Амар тайван-Өвөрхангай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Цагдаагийн албаны, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрх, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, Архидан согтуурахтай тэмцэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд болон бусад хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэсгийн байцаагч, багийн цагдаа нарын ажиллах орчин нөхцөл, албаны унаа, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, улмаар иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд үр дүн гарах юм.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх "Эцэг, эхийн зөвлөл"-ийн нэгдсэн зөвлөгөөнд амжилттай оролцов.

Уг зөвлөгөөнд аймгийн хэмжээнд 19 сумын 144 байгууллагын дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулагдаж, 500 орчим хүн гишүүнээр ажиллаж байна.

Тус зөвлөгөөнд 19 сумын 140 байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдын төлөөлөл 198 хүн оролцож, "ГЭР БҮЛЭЭ ЭРХЭМЛЭЖ, ХАЙР ДҮҮРЭН ДУРСАМЖИЙГ БҮТЭЭЦГЭЭ" уриалгыг гаргаж, "Сэтгэлийн өнгө төв"-ийн захирал сэтгэл зүйч Т.Наранбаатар оролцож "ТОГТВОРТОЙ ГЭР БҮЛ АЖИЛ АМЬДРАЛЫН ҮНДЭС" сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг оролцуулан хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн болон орон нутгийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон ажлын үр дүн, хамтын ажиллагаа, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шинэ санал санаачилга хэрэгжүүлэх, хүүхэд хохирсон, оролцсон гэмт хэргийн гаралт өсөх болсон шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой "Анхаарч хамгаалъя" хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн уулзалт хэлэлцүүлэг энэ оны 02 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав.

Уулзалт хэлэлцүүлэгт Аймгийн Засаг дарга, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжил, Прокурор, Боловсрол шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 17 байгууллагын 100 гаран ажилтан албан хаагчид хамрагдсан. Хэлэлцүүлэгт насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх танилцуулга мэдээлэл танилцуулав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор иргэн 385, төрийн болон төрийн бус байгууллага 155, хамтарсан баг 36-г татан оролцуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 308 төрийн байгууллага, төрийн бус байгууллага, 661 аж ахуйн нэгж, 11726 иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажилласан байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн гэрээ байгуулан олон нийтийн цагдаа 12, малчдын бүлэг холбоо, нөхөрлөл 22, хөршийн хяналтын бүлэг 51, хамтарсан баг 124, сургуулийн эргүүл 62, өсвөрийн сэргийлэгч бүлгэм 31 нийт 1196 гишүүдтэй хамтран эрх ашиг нь зөрчигдсэн хүүхэд, эмэгтэйчүүд рүү чиглэсэн нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 55 удаа мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж байна.

Арвайхээр сумын Зүлэгт 12 дугаар багт энэ оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүн олноор цугларч архи дан согтуурдаг цэгүүд, архи согтууруулах ундаа худалдах буюу түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдааны төвүүдэд хяналт шалгалт хийх, аливаа эрсдэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөршийн холбоог сайжруулах, харуул, хамгаалалтын ажилтан, манаач нарын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хөршийн холбоог сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гудамж хариуцсан хэсгийн ахлагч нарын эргүүлийг санаачлан Арвайхээр сумын 12 дугаар багийн ажлын албатай хамтран ажиллуулсан.

Хэсгийн ахлагч нарыг эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд мэргэжилтэн, хэсгийн байцаагч, багийн цагдаа нараас мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, үүрэг, чиглэлээр ханган ажиллаж байна.

Уг эргүүл ажилласнаар хөршийн холбоо сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурах эерэг үзүүлэлт гарах юм.

Мөн баг тус бүр дээр явуулын үйлчилгээг зохион байгуулахаар уг ажлыг эхлүүлээд байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 7-21 хоногийн хугацаагаар баривчлагдаж,

иргэдэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, “Арисахуйн Үндэс” ТББ-тай хамтран, зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны сургалтыг 19 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 92 иргэн хамрагдсан байна.

**Дөрөв.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх. /ГХЗУСТХ-ийн 9-р зүйл/**

4.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 166 мэдэгдлийг хүргүүлснээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчаас 30 мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж, 4 мэдэгдлийн биелэлтийг газар дээр нь шалгаж, 91 мэдэгдлийн хариуг авч, бусад мэдэгдлийн биелэлт үр дүнг тооцох хугацаа болоогүй 77 мэдэгдэл байна.

4.2 Ажлын мэдээний 29, 30 дугаар баганад заагдсан Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй 289 иргэнийг “Судалгаа хяналтын сан”-д бүртгэв.

Оны эхэнд 23 хүн захиргааны хяналтад байснаас 10 хүнийг хяналтаас хасч, 14 хүнийг нэмж хяналтад авч, одоогийн байдлаар 27 хүн хяналтад байна. Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдэд хяналт тавьж засрал хүмүүжил олгосон 10 иргэн байна.

**Тав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх. /ГХЗУСТХ-ийн 10-р зүйл/**

5.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга, яриа, сургалт, сурталчилгаанд 64754 иргэн хамрагдсаны дотор хувиараа хөдөлмөр эрхлэгч 12694, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан 33459, малчин 4212, оюутан 270, сургууль завсардсан хүүхэд 21, сурагч 2620, ажилгүй 11298 иргэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ухуулга сурталчилгааны ажилд нийт 746 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсаны дотор төрийн байгууллага 163, ТББ 48, аж ахуйн нэгж 520, их дээд сургууль коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2, ерөнхий боловсролын сургууль 8, цэцэрлэг 5 хамрагдсан.Иргэд, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө, мэдээ, мэдээллийг аймгийн төв Арвайхээр суман дахь Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд иргэдэд анхан шатны хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл үзүүлэх зорилгоор цахим эрх зүйн хөтчийн булан буюу цахим хөтчийн дамжуулан хууль, эрх зүйн мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна.

"НЭЭЛТТЭЙ ХААЛГА"-ны өдөрлөгт алба хаагчид оролцож, үеэр иргэд, хүүхэд, багачуудад цагдаагийн албаны дүрэмт хувцас, тусгай хэрэгслийг сурталчлан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, мэдээлэл хүргэв.

Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн [www e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хуудсанд болон Цагдаагийн газрын цахим хуудас, вэб сайтад Цагдаагийн ерөнхий газрын газрын Хэвлэл, мэдээллийн төв болон Урьдчилан сэргийлэх хэлтсийн цахим хуудаст нийтлэгдсэн видео контент, цуврал хичээл, шторкуудыг шэйрлэн түгээхээс гадна аймгийн хамгийн олон дагагчтай 20-30 группт түгээлт хийж, орон нутгийн 1 телевиз, аймгийн албан ёсны цахим хуудсаар иргэдэд мэдээлж сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулан ажилласан нь иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй байлаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, “Ариусахуйн үндэс” төрийн бус байгууллага, Насан туршийн боловсролын төвийн сургагч багш нартай хамтран эрүүлжүүлэх баривчлах байранд баривчлагдсан иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ялангуяа хүчирхийлэл үйлдэгч иргэдийн зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны сургалтыг 7 хоног бүр зохион байгуулахаар хамтран ажиллах албан бичгийг хүргүүлэн, давхардсан тоогоор 926 иргэнд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Гэр бүлийн хүчирхийллийн



тухай ойлголт, хүлээх хариуцлага”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн харилцаа, хандлага”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Эр хүний эрх, үүрэг хариуцлага”, “Амьдрах ухаан”, “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ” зэрэг сэдвүүдээр сургалт, мэдээлэл өгч, иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тус газраас Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Нуугдмал”, “Хамтдаа хамгаалъя” аяны хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүүхэд багачуудад хүрэхүйн тухай ойлголтыг өгөх зорилгоор Арвайхээр сумын 2,7 дугаар цэцэрлэгийн 24 багш, ажилтан, 35 эцэг эхчүүд, 84 хүүхэд багачууддаа “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт”, “Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт”, “Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах нь”, “Хүүхэд хамгаалал”, “Хүрэхүйн тухай ойлголт” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, “Улаан гэрэл, улаан бөмбөлөг” дууг дууллаа.

“Хүүхэд хамгаалал”, “Бүртгэл”, “Анхаарч хамгаалъя”, “Хамтдаа хамгаалъя” аян, арга хэмжээний хүрээнд Арвайхээр сумын 1, 9, 12 дугаар багийн хэсгийн ахлагч 36 иргэнд “Архины хор хөнөөл”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, мэдээлэх үүрэг хариуцлага”, “Хүүхдийн эрх хамгаалал, эцэг, эхийн үүрэг оролцоо, хүлээх хариуцлага” сэдвээр сургалт, мэдээлэл хийж, санамж, сэрэмжлүүлэг, постер тарааж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч, “Хөршийн холбоо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлэхээр шийдвэрлэлээ.

Баян-Өндөр сумын ЕБС-ийн 8а ангийн 32 сурагчдад “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Электрон тамхины хор нөлөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдвээр сургалт, мэдээлэл хийв.

Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сэтгэл зүйчтэй хамтран, “Мэргэжил ба сонголт” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, “Хүүхдийн эрх, хамгаалал”, “Цахим орчны хэрэглээ”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдвээр сургалт, мэдээлэл хийж, нийт 180 сурагч хамрагдлаа.

“Хүүхэд хамгаалал”, “Бүртгэл”, “Анхаарч хамгаалъя”, “Хамтдаа хамгаалъя” аян, арга хэмжээний хүрээнд “Уралдаанч хүүхдээ анхаарч хамгаалъя” уяач, уралдаанч хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчдын аймгийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулагдаж, нийт 248 иргэн оролцсон бөгөөд “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо ба үүрэг хариуцлага” сэдвээр мэдээлэл хүргэж, хамтран ажилласан.

Хужирт сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг, эхчүүд, нийт 67 иргэнд “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээх хариуцлага”, “Хүүхдийн эрх хамгаалал, мэдээлэх үүрэг хариуцлага”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдвээр тус тус сургалт орж, иргэдийн асуусан асуултад хариулт өгөв.

Арвайхээр сумын 5 дугаар багийн ажлын албатай хамтран, тус багт үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүрийн эзэд, худалдагч 21 иргэнд “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээх хариуцлага”, “Хүүхэд хамгаалалд эцэг, эхийн үүрэг, оролцоо”, “Архины хор хөнөөл” сэдвээр сургалт зохион байгуулж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч, мэдээллээр ханган ажилласан.

Арвайхээр сумын 1,9,12 багийн ажлын албадтай хамтран хэсгийн ахлагч нарт сургалт зохион байгуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл зохион байгуулахаар төлөвлөгөө гаргахаар болж, иргэдийг архинаас татгалзах уриалгыг гарган ажиллав.

“Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр”-т зориулж гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Шийтгэл бол Шийдэл биш” сэдэвт “Дэвжээ” тэмцээнийг Уянга сумын

иргэдийн дунд зохион байгууллаа.

Баян-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуультай хамтарч "Хөгжилтэй өртөө" эцэг эхийн өдөрлөгийг зохион байгуулав.

5.2 Ажлын мэдээний 44-57 гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео мэдээ, шторк 22, гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэл 5, зурагт хуудас постер 80, гудамж, талбайд байрлах лед дэлгэцээр 6, аж ахуйн нэгж байгууллагын хүлээлгийн танхимын 7, байгууллагын хүлээлгийн танхимын 4 лед дэлгэцээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн ажилласан.

5.3 Ажлын мэдээний 48-50 дахь баганад заагдсан ажлын хүрээнд зурагт хуудас 80, санамж сэрэмжлүүлэг 35 нийт 19473 ширхгийг олшруулан тараасан.

5.4 Ажлын мэдээний 51-53, 54-57 дахь баганад заагдсан ажлын хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагад 13 удаа мэдээг өгч, Uvlive.mn, GM телевизэд 6, "Дөрвөн эрдэнэ студи"-д 6, байгууллагын цахим хуудаст 64 мэдээлэл боловсруулан нийтэлсэн.

Иргэд олноор үйлчлүүлдэг томоохон зах, худалдаа үйлчилгээний газруудаар иргэдийг хулгайд эд зүйлээ алдахаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, 80 төрлийн зурагт хуудасны 19823 ширхгийг олшруулан тараан байршуулж, 24 ерөнхий боловсролын сургуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлага хүргүүлсэн.

Өвөрхангай аймгийн цагдаагийн газар цахим фэйсбүүк хуудас болон Өвөрхангай аймгийн цагдаагийн газар вэб сайтаар дамжуулан хулгайлах, залилан мэхлэх, цахим гэмт хэрэг, чи ганцаараа биш, эрүүгийн хуулийн зүйл заалтаар, согтууруулах ундааны хор уршгийн талаарх 136 удаагийн зурагт хуудсыг орон нутгийн олон дагагчтай зарын цахим группүүдэд байршуулснаар 1022 удаа түгээлт хийж, иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.

Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон Хэвлэл мэдээллийн төв, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн цахим хуудсанд байршуулсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтлэгдсэн 576 удаагийн зурагт хуудас, видеог байгууллагын цахим хуудсанд байршуулж орон нутгийн олон дагагчтай зарын цахим хуудас, бүлгүүдэд түгээлт хийсэн.

**Зургаа.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах, төлбөртэй мэдээ авах.**

#### **/ГХЗУСТХ-ийн 34.35-р зүйл/**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл авагдаагүй байна.

Энэ оны төсөвт 6.000.000 /зургаан сая/ төгрөгийг суулгасан. 2022 онд хамтран ажилласан гэрээгээ дүгнэж, Богд, Бат-Өлзий, Өлзийт, Хархорин, Арвайхээр сумдын Засаг дарга нарыг Цагдаагийн газрын "Талархал", дурсгалын зүйлээр,

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон сайн дурын идэвхтэй иргэн Д.Шийлэгбат, С.Дашням, Г.Сүхбаатар нарыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн "Хүндэт өргөмжлөл", 210.000 /хоёр зуун арван мянган/ төгрөгөөр, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй ажилласан иргэн Х.Гэрэлмаа, Г.Мөнх-Эрдэнэ нарыг аймгийн Цагдаагийн газрын "Баярын бичиг", 40.000 /дөчин мянган/ төгрөгөөр тус тус шагнаж, урамшуулав.

#### **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ:**

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд "Бүртгэл", аймгийн хэмжээнд "Судалгаа, хяналтын сангийн баяжилт", "Харилцан хүндэтгэе", "Анхаарч хамгаалъя" зэрэг 4 аян, арга хэмжээг зохион байгуулав.

**Уг хэмжээний хүрээнд "Таниулъя, илрүүлъя, мэдээлье", "Уралдаанч хүүхдээ**

анхаарч хамгаалъя”, “Эергээр манлайлъя” зэрэг чуулган, уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 51 төрийн болон төрийн бус байгууллагын 528 ажилтан, алба хаагчид оролцож, мэдээлэл солилцон ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 220 иргэний судалгааг шинэчлэн гаргаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн субъектийн бүртгэлийн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн бүртгэл”-д 445 иргэнийг шивж оруулан, хяналт тавин ажиллаж байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 91 иргэдийн гэрээр орж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч нартай уулзан бүртгэл хөтлөн, зөвлөгөө, зөвлөмж, яриа таниулга хийж, мэдээллийг санд шивж оруулан ажилласан.

Мөн архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 38 иргэнийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн наркологийн тасагтай хамтран сайн дурын эмчилгээнд хамруулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын баталсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад ажиллах” удирдамжийн дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Хүний эрхийн Үндэсний комиссын хүүхдийн эрхийн асуудал хариуцсан иргэний нийгмийн зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдад Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багийн ажлыг арга зүйгээр ханган чадавхжуулж, шалган, зөвлөн тусалж, хяналт тавин ажилласан. Хамтарсан багийн гишүүд болон хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн төрийн алба хаагч, эцэг, эхчүүдэд “Нэгдүгээрт хүүхэд”, “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлага”, “Хүчирхийллийг үл тэвчих, нийгмийн эерэг сэтгэл зүй, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх”, “Нийгмийн стрессийг нийлж засъя”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 1419 иргэнийг хамруулж, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан.

Эрүүлжүүлэх баривчлах байранд баривчлагдсан иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ялангуяа хүчирхийлэл үйлдэгч иргэдийн зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны сургалтыг 7 хоног бүр зохион байгуулахаар хамтран ажиллах албан бичгийг хүргүүлэн, давхардсан тоогоор 257 иргэнд 24 удаагийн сургалт, мэдээлэл өгч, иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.

Мөн Арвайхээр сумын 13 багт “Хөршийн хяналтын бүлэг” буюу 15 хэсгийн ахлагчийн эргүүлийг гэр бүлийн хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулж эхэллээ. Мөн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Арвайхээр сумын 13 багт “Явуулын үйлчилгээ”-г зохион байгуулахаар төлөвлөн эхлүүлээд байна. Уг үйлчилгээ нь багийн нутаг дэвсгэрт хууль, эрх зүйн болон сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилготой юм.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт 113, уулзалт, хэлэлцүүлэг 10, өдөрлөг 6, уралдаан, тэмцээн 2, нийт 131 удаа зохион байгуулагдаж, нийт 6506 иргэн хамрагдсан байна. Мөн урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага 1, зурагт хуудас 16, нийт 1500 ширхгийг олшруулан тарааж, “GM” телевизэд 1 мэдээлэл, цахим сайт 5, байгууллагын цахим хуудаст 16 постер бэлтгэж, хуваалцсан тоо 85, хандалтын тоо 235692 иргэн, олон нийтэд түгээж, хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэв.

Энэ оны эхний 5 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл 108 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 25 нэгжээр буюу 18.9 хувиар, Зөрчлийн тухай хуулийн 5.4 зүгээр зүйлд заасан зөрчил 95 бүртгэгдэж, өмнөх оны

мөн үеэс 13 нэгжээр буюу 12.0 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 30 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 12 нэгжээр буюу 28.6 дахин, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”-д заасан гэмт хэрэг 1 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 4 нэгжээр буюу 80 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь сургалт, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил үр дүнтэй зохион байгуулагдсан гэж дүгнэж байна.

### **ХҮҮХЭД ХОЛБОГДСОН БОЛОН ХОХИРСОН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Хүүхэд хамгаалал”, “Нуугдмал”, “Хамтдаа хамгаалъя”, аймгийн хэмжээнд “Хүүхэд хамгаалалд бидний оролцоо”, “Буудал”, “Анхаарч хамгаалъя” зэрэг 6 аян, арга хэмжээг зохион байгуулсан.

Уг арга хэмжээний хүрээнд “Таниульа, илрүүлэе, мэдээлье”, “Уралдаанч хүүхдээ анхаарч хамгаалъя”, “Эергээр манлайлья” зэрэг чуулган, уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 51 төрийн болон төрийн бус байгууллагын 528 ажилтан, алба хаагчид оролцож, мэдээлэл солилцон ажиллалаа. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа нийт 24 буудалд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр 8 албан мэдэгдэл хүргүүлэн, биелэлтийг тооцон ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэгч үйлдэгч, үйлдэж болзошгүй этгээд болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байхад хяналт тавих зорилгоор **“Судалгаа хяналтын сангийн баяжилт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж**, эрсдэлт нөхцөлд байгаа 454 хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн субъектийн бүртгэлийн “Хүүхдийн нэгдсэн бүртгэл”-д бүрэн шивж оруулан, хяналт тавин ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын баталсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад ажиллах” удирдамжийн дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Хүний эрхийн Үндэсний комиссын хүүхдийн эрхийн асуудал хариуцсан иргэний нийгмийн зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдад Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багийн ажлыг арга зүйгээр ханган чадавхжуулж, шалган, зөвлөн тусалж, хяналт тавин ажилласан. Хамтарсан багийн гишүүд болон хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн төрийн алба хаагч, эцэг, эхчүүдэд “Нэгдүгээрт хүүхэд”, “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлага”, “Хүчирхийллийг үл тэвчих, нийгмийн эерэг сэтгэл зүй, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх”, “Нийгмийн стрессийг нийлж засъя”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 1419 иргэнийг хамруулж, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 23 цэцэрлэг, ерөнхий боловсролын 27 сургуулийн бага, дунд, ахлах ангийн болон Политехникийн коллежийн 1, 2 дугаар курсийн нийт 3485 хүүхдэд, 2592 эцэг, эх, асран хамгаалагч, багш ажилтан нарт 7 төрлийн сэдвээр сургалт зохион байгуулж, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, мэдлэг хандлагыг дээшлүүлэв.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт 113, уулзалт, хэлэлцүүлэг 10, өдөрлөг 6, уралдаан, тэмцээн 3, нийт 132 удаа зохион байгуулагдаж, нийт 6506 иргэн хамрагдсан байна. Мөн урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага 1, зурагт хуудас 16, нийт 1500 ширхгийг олшруулан тарааж, “GM” телевизэд 1 мэдээлэл, цахим сайт 5, байгууллагын цахим хуудаст 16 постер бэлтгэж, хуваалцсан тоо 92, хандалтын тоо 297692 иргэн, олон нийтэд түгээж,

хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэв.

Энэ оны эхний 5 сарын байдлаар хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэрэг 10 бүртгэгдэж, өмнө оны мөн үеэс 2 нэгжээр буюу 25 хувиар өсөж, хүүхэд хохирсон гэмт хэрэг 23 бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 3 нэгжээр буюу 11.5 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил үр дүнтэй зохион байгуулагдсан гэж дүгнэж байна.

### **ДӨРӨВ. САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР**

Тус цагдаагийн газар нь 2023 оны эхний 5 сарын байдлаар улсын төсвөөс 1,392,188.8 мянган төгрөг, өөрийн орлогоос мянган төгрөг нийт 25,171.4 мянган төгрөгийн зарцуулах эрхтэй үүрэг гүйцэтгэснээс 1,359,174.1 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаад байна. Зарцуулалтын гүйцэтгэл 95,7%. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 1,174,149.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 24,323.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 70,709.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 60,038.1 мянган төгрөг, нормативт зардалд 6,903.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 10,679.3 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 5,202.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 7,169.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 0,0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 0,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан. Өөрийн орлогын төлөвлөгөө 25,171.4 мянган төгрөг, төвлөрүүлсэн орлого 35,878.8 мянган төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд тус оны эхний 5 сарын байдлаар аймгийн ИТХурлаас “Шилдэг мөрдөгч” тэмцээний зардал 1,200.0 мянган төгрөг, Арвайхээр сумын ЗДТГ-аас үйл ажиллагааны дэмжлэг зардлаар 15,0 сая төгрөг орж ирж зарцуулалтыг хийж ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган шилэн дансны нэгдсэн системд байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, баланс, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2023 оны 01-05 дугаар саруудын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, орон тооны судалгаа, тушаал шийдвэр зэрэг сар бүр оруулбал зохих 4, тухай бүрт оруулах 7, улирал бүр оруулах 2 мэдээлэл оруулсан. Уг мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь оруулж админ эрхээр Санхүү аж ахуйн албанд илгээхээр ажиллаж байна.

### **ТАВ. АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ХАНГАХ,**

**Эрүүл мэндийн болон бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хамгаалах алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах аливаа халдварт болон халдварт бус өвчлөл түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдтэй хамтран ажиллаж байна. Цаашид алба хаагчдыг энэ оны 9 дүгээр сард Хужирт 10, Сүүж уулын амралтад 10 алба хаагчийг үзлэгийн дүнг үндэслэн рашаан сувилалд, мөн 16 алба хаагчийг Улаанбаатар хот 3-р шатлалын эмнэлэгт үзүүлж онош тодруулах, гэмтэж бэртсэн алба хаагчдыг Үйлдвэрлэлийн осол, гэмтлийг судлан бүртгэх, Хөдөлмөр аюулгүй байдлын орон бус зөвлөлөөс заавар зөвлөмжийг өгч тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч байна. Бие бялдрыг хөгжүүлж эрүүл мэндэд анхаарах үүднээс 7 хоног бүрийн 2 дахь өдөр болгон зааланд тоглох, тасагт хуваарийн дагуу хамт олноороо фитнесст үр дүнтэй хичээллүүлэх усан бассейн зэрэг спортын арга хэмжээг гарсан төлөвлөгөө гэрээний дагуу зохион байгуулан алба хаагчдыг 1км-3км гүйлтэд давтамжтайгаар хамруулан ажилласан.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны эмч нарыг эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулж

кредит цагийг бүрдүүлэн эмчлэх эрхийг сунгуулах боломжийг бүрдүүлэн сэтгэл зүйн чиглэлээр нийт 190 алба хаагчдыг 6 төрлийн судалгаанд хамруулж цагдаагийн газрын сэтгэл зүйчээс зөвлөгөөг авч нийт алба хаагч ажилтныг Аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлгүүд, сумдын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран үзлэг шинжилгээд 100 хувь 3 дугаар улиралд багтаан хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн

Цагдаагийн газрын алба хаагчдын “Биеийн жингийн индекс”-ийг тодорхойлох ажлыг 2023 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд бие бялдрын шалгалтыг 5 үзүүлэлтээр авч. БЖИ үзэхэд Хэвийн жинтэй-85, жингийн илүүдэлтэй-25, таргалалт I зэрэг-11, таргалалт II зэрэг-3 алба хаагч байна. Судалгааны үр дүнг тасаг нэгжийн дарга нар, алба хаагчдад амаар болон бичгээр танилцуулж эрүүл хооллолт, жингээ хэрхэн зөв аргаар хасах талаар заавар зөвлөмж, гарын авлага өгч ажилласан. Эрүүл мэндийн үзлэгийн дүнг үндэслэн 45 алба хаагч, ажилтанд Аминно хүчил, Хөдөлмөр аюулгүй байдлын чиглэлээр танхимаар 1 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

#### **Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр:**

Цагдаагийн газрын спорт хамтлагийн гишүүдийг энэ оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулж, спорт хамтлагаас ажлын төлөвлөгөө, хуваарийг 42 заалттай гаргаж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Цагдаагийн газрын алба хаагчдаас улсыг аварга шалгаруулах тэмцээнд 2, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 5, дотоодоо 7 тэмцээн зохион байгуулж, аймгийн төрийн цэргийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 5 төрлийн тэмцээн, эмэгтэй алба хаагчдын дунд 1, нийт алба хаагчдын дунд 1 удаа аялал зохион байгуулж ажилласан. Энэ оны хагас жилийн байдлаар улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль 2, аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 3, мөнгө 1, хүрэл 5, Цагдаагийн ерөнхий газрын аварга шалгаруулах 7 төрлийн тэмцээнд оролцож 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн байна.

#### **ЗУРГАА. ДОТООД ХЯНАЛТЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АЛБАНЫ ШАЛГАЛТЫН ТАЛААР;**

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хуралдаж цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах 7 бүлэг 41 заалт төлөвлөгөөг боловсруулсан. Байгууллага, алба хаагч нарт учирт болзошгүй эрсдэлийг тухай бүр бодитоор тодорхойлох чиглэлээр цагдаагийн газрын нийт алба хаагч нараас эрсдэл, аюулгүй байдлын талаар саналыг авч нэгтгэсэн. Тасаг, алба хаагчдаас үндэслэл бүхий 8 саналыг гаргасан байна. Иргэдээс цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбогдуулан 10 гомдол мэдээлэл ирснийг нэгдсэн бүртгэлд хөтлөн, хуулийн хугацаанд шалгаж хариу хүргүүлээд байна. Тус хугацаанд алба хаагч нараас гэмт хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах” код 242 журамд заасныг баримтлан хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах талаар цагдаагийн газрын нийт алба хаагч нараас баталгаа авсан.

Мөн ажлын байранд, ажлын цагаар эсхүл цагдаагийн дүрэмт хувцастай архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй, албан үүрэг гүйцэтгэх буюу хувийн ажлаар албаны болон хувийн автомашин жолоодож замын хөдөлгөөнд оролцохдоо архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар нийт алба хаагч нараас баталгаа авсан байна. 2023 оны эхний хагас жилд цагдаагийн газарт шинээр томилогдсон 12, албанаас чөлөөлөгдсөн 4 алба хаагчаас Төрийн болон албаны нууцыг хадгалах талаар бичгээр баталгаа авсан. 2023 оны эхний хагас жилд ЦЕГ-ын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчийн аюулгүй байдалтай холбоотой 11 албан бичиг ирснийг бүртгэлд авч алба хаагч нарт танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **ДОЛОО: ХАРХОРИН СУМЫН СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТЭС**

### **Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, нэгдсэн ба хэсэгчилсэн арга хэмжээний дагуу 34 салбар төлөвлөгөө гарган, төлөвлөсөн ажлыг шат дараалан хэрэгжүүлж, биелэлт үр дүнг хугацаанд нь тооцон ажилласан.

Цагдаагийн ерөнхий газар, удирдах харьяа албад, төв орон нутгийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 998 албан бичгийг бүртгэлд авч, энэ хугацаанд хариутай 625 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн 495 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 130 албан бичгийн биелэлт үр дүнг тооцох хугацаа болоогүй байна. Цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгөө гарган батлуулж 6 удаагийн хуралдаан зохион байгуулж 40 төрлийн асуудлыг хурлаар оруулж шийдвэрлэн, цагдаагийн хэлтсийн даргын А тушаал 18, Б тушаал 9 гаргаж биелэлт үр дүнг тооцсон.

Мөн цагдаагийн хэлтсийн даргаас алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ажлыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангахаар 16 үүргийн хуудас, 4 зөвлөмж, 1 зааварчилга өгч, хэсэг, тасгийн болон чиг үүргийн албадын алба хаагчдын ажлын ажлын явцтай танилцаж 6 дугаартай 48 үүргийг үүргийн товчоогоор алба хаагч нарт хүргүүлж биелэлт үр дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцсэн.

**Хүний нөөцийн чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан орон тоогоор тус хэлтэс 68 алба хаагчтай, офицер 36, ахлагч 29, энгийн ажилтан 3 ажилтантай. Үүнээс хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, хамгаалалтын цагдаа 1, Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны цагдаа 1, хэсгийн төлөөлөгч 1 нийт 4 орон тоо дутуу ажиллаж байна. Ээлжийн амралт эдэлсэн 16, ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 2, дотоод шилжилт хөдөлгөөн 2, өөр анги байгууллагад шилжин томилогдсон 6, өөр анги байгууллагад шилжин томилогдсон 6, ахлах албан тушаалд дэвшин томилогдсон 2 алба хаагч байна.

**Алба хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар хэлтсийн даргын тушаалаар 3 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан. Алба хаагчдын ажлын хариуцлага албаны бэлэн байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөөний дагуу “Ц-111” дохиогоор түргэн цугларалт 7 удаа зарлаж албаны бэлэн байдлыг шалгасан.

### **Хоёр. Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр:**

Мэдээлэл, сурталчилгаа болон соёл хүмүүжлийн ажил зохион байгуулах үүрэг бүхий Цагдаагийн хэлтсийн даргын 2022 оны А/36 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгээс алба хаагчдын ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх, ажлын стрессийг тайлж, хамт олонч, нийтэч уур амьсгалыг бүрдүүлэх, эерэг харилцаа хандлагыг бий болгох зорилгоор соён гэгээрүүлэх спорт, урлагийн 18 ажил арга хэмжээнд давхардсан тоогоор 1507 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан.

Албаны сургалт зохион байгуулах төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр мэдвэл зохих хууль тогтоомж, алба хаагчийг хөгжүүлэх сургалт, дадлагажуулах сургалт гэсэн 3 чиглэлээр нийт зохион байгуулах сургалтын 41 сэдэв батлуулж дотоод албаны сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулсан бөгөөд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 12, алба хаагчийг хөгжүүлэх сургалт 6, дадлагажуулах сургалт 2, нийт 20 сургалтыг 2038 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан байна.

Энэ онд шинэлэг ажил арга хэмжээ зохион байгуулах, алба хаагчдыг сурган дадлагажуулах, чадавхжуулах зорилгоор Сум дундын Прокурорын газартай хамтран “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдыг чадавхжуулах” хөтөлбөрийг 2 байгууллагын удирдлагын баталснаар сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргаж прокурорын байгууллага, цагдаагийн хэлтсийн мөрдөн шалгах ажиллагаа хариуцсан дарга, ахлахууд болон байгууллагын удирдлагаас нийт 2 сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцсон.

**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулсан ажлын талаар:** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 55 төрийн байгууллага, төрийн бус байгууллага, 154 аж ахуйн нэгж, 150 иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажилласан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн гэрээ байгуулан олон нийтийн цагдаа 11, сайн дурын урамшуулалт эргүүл 12, малчдын бүлэг холбоо, нөхөрлөл 12, хөршийн хяналтын бүлэг 14, хамтарсан баг 3 нийт 124 гишүүдтэй хамтран эрх ашиг нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүд рүү чиглэсэн нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 56 удаа мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралтад дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт “Хүүхэд хамгаалал-2023”, “Цаг гаргая” “Илрүүлэлт”, “Нуугдмал”, “Зочид буудал”, “Мэдэгдэл”, “Төгсөлт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулж ажилласан нь урьд оны мөн үетэй харьцуулахад хэргийн гаралт буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иргэдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах зорилгоор Цахим хуудсыг хөгжүүлэх чиглэлээр цэс бүрээр засварлаж 36 мэдээ мэдээлэл нийтэлсэн.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЦЕГ болон бусад газраас хэлтсээс зохион байгуулсан 278 шторк, санамж, сэрэмжлүүлэг, видео контентуудыг Хархорин болон харьяа тойргийн сумдын олон дагагчтай группүүдэд давхардсан тоогоор 430000 орчим түгээлтийг хийж ажилласан.

Алба хаагчдаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 16, урьдчилан сэргийлэх чиглэлээр 28 албан мэдэгдэл бичсэнийг биелэлт үр дүнд нь хяналт тавин ажиллалаа.

Хархорин суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 11 төрийн байгууллага оролцож, өдөрлөгийн үеэр санамж сэрэмжлүүлэг хүргэн 250 ширхэг зурагт хуудас тарааж ажиллав.

**Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Тус цагдаагийн хэлтэст хүүхэд өртөж хохирсон гэмт хэрэг 3, зөрчил 4 бүртгэгдсэн. Хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.

2022 оны мөн үед хүүхэд өртөж хохирсон, хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй ба энэ онд өрхөөр хяналт шалгалт хийж ажилласны үр дүнд хүүхэд хохирсон зөрчлийг илрүүлж, зөрчлийг таслан зогсоож, арга хэмжээ тооцсон.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ахуйн хүрээнд архи дан согтуурдаг байж болзошгүй 4 өрхөд хяналт тавин ажилласан ба хяналт шалгалтын хүрээнд насанд хүрээгүй хүүхдийн дэргэд архи дан согтуурч байсан 2 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуульд зааснаар 2 иргэнд 600.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, бага насны хүүхдийг зодсон 1 зөрчлийг шалган хэрэг бүртгэлийн хэрэг нээхээр, 1 иргэнийг сум дундын шүүхээр 7 хоногийн хугацаагаар баривчлуулж, 1 хэргийг татгалзаж, одоо 2 зөрчлийн хэрэг ажиллагаанд байна.

Хүүхэд хохирч болзошгүй 2 өрхөд хяналт тавьж, Хархорин сумын хамтарсан багт 2 өрхийн 7 хүүхдэд хяналтын кэйс нээлгэн, 2 хүүхдийг улсын цэцэрлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан.

Эрсдэлт бүлгийн 47 хүүхдийн судалгааг гаргаж үүнээс эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул эрсдэлд өртөх магадлалтай бага насны 17 хүүхдийн судалгааг гарган цаашид холбогдох сургуулийн багш, нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах чиглэлээр ажиллаж байна. Дээрх 17 хүүхдээс 2



хүүхдийн гэрээр хяналт шалгалт хийж сумын хамтарсан багт мэдээллийг хүргүүлж, кэйс нээн хяналт тавих ажлыг зохион байгуулсан.

Хархорин суманд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулдаг Солонго төвийн 14 хүүхдээс 12 хүүхэдтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг авч, ярилцлага зохион байгуулан “Хүүхдийн эрхийн тухай ойлголт” сэдвээр, Хархорин сумын 2-р цэцэрлэгийн эцэг, эхчүүдэд хүүхдийг цахим донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цахим орчны хэрэглээ” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.

Эрсдэлт бүлгийн болон хараа хяналт сул, гэмт хэрэг зөрчилд өртөж хохирч болзошгүй 43 хүүхдийн мэдээллийг судалгаа хяналтын санд шивж баяжилт хийсэн.

Насанд хүрээгүй хүүхдэд архи, согтууруулах ундааны зүйл, утаат болон электрон тамхи худалдан борлуулах зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хархорин суманд үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл бүхий 42 аж ахуйн нэгжид 2 төрлийн албан мэдэгдэл, мөн Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хархорин сумын Их хурд морин спорт уяачдын холбоонд 1 албан мэдэгдэл, ерөнхий боловсролын сургуулиудын 2022-2023 оны хичээлийн “Эрдмийн баяр” болохтой холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4, 64.5, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 29 дүгээр зүйлийн 29.1.10, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт тус тус зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээг зохион байгуулах ажиллах 9 заалт бүхий шаардлага тус тус хүргүүлж, биелэлтийг тооцсон.

#### **Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Хэлтсийн хариуцсан тойргийн сумдын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн нийт 37 дуудлага мэдээллийг хүлээн авч шалган 37 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн 34 иргэнийг сум дундын шүүхээр 7-30 хоногийн хугацаанд баривчлуулан, 1 иргэнийг 300,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч ажилласан байна.

Бүртгэгдсэн дуудлага мэдээллийг цагдаагийн байгууллагын ECS программд бүрэн оруулж, аюулын зэргийн үнэлгээ хийж байгаа эсэхэд өдөр бүр хяналтыг тавин ажиллаж байна.

Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлддэг 2 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, эрсдэлт бүлгийн 6 дуудлага мэдээллийн 5 холбогдогч, гэр бүлийн талаар мэдээллийг сумын хамтарсан багт хүргүүлж, баривчлагдсан 34 иргэнд давхардсан тоогоор 21 удаагийн сургалт зохион байгуулсан.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Үжин төрийн бус байгууллагатай хамтран “Үйлдлээрээ үлгэрлэгч Хархорин” аяныг зохион байгуулсан.

Хархорин суманд “АА” бүлгэмийг байгуулж Архины хамаарал бүхий иргэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй иргэдийг сургалтад хамруулах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. АА бүлгэмийн гишүүдтэй хамтран нийт 12 удаагийн сургалтад цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 154 иргэнийг хамруулсан байна.

Ариусахын үндэс төрийн бус байгууллагатай хамтран “Гэр бүлийн үнэ цэн”, “Гэр бүл байхын утга учир” сэдэвт сургалтыг 18 удаа 118 иргэнийг хамруулан зохион байгуулсан.

#### **Дөрөв: Хэсэг, албадаас хийж гүйцэтгэсэн ажлын талаар:**

**4.1. Мөрдөн байцаах хэсэг:** Мөрдөн байцаах хэсэг нь хэсгийн дарга 1, ахлах мөрдөгч 2, мөрдөгч 2 орон тоотой бөгөөд харьяа сум дахь тасгийн мөрдөгч 2 орон тооны алба хаагчдын мөрдөн шалгах чиглэлийн үйл ажиллагааны чиглэлээр хяналт

тавьж ажилласан. Хэсгийн дарга мөрдөгч нарын шалгаж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нэг бүртэй өдөр тутам танилцаж, хэргийг шуурхай шалгаж шийдвэрлүүлэхийн тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг шийдвэрлэх графикийг сараар гаргаж биелэлтэд тогтмол хяналт тавьж удаашран шалгагдаж байгаа хэргүүдийг уншиж танилцан нийт 54 зааварчилга, үүнээс алба хаагчдын өдөр тутмын ажлын үүрэг гүйцэтгэл, сахилга ёс зүйн чиглэлээр 5 зааварчилга, мөрдөн шалгах ажлын чиглэлээр 49 зааварчилга өгч биелэлт тооцон, 2 “Зөвлөмж” хүргүүлж биелэлт, үр дүнг нь хугацаанд нь тооцсон.

Мөрдөн шалгах ажлын чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт **99** гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 22 гомдлоор өссөн байна. Хүлээн авсан 99 гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал **42** гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 2-оор буюу 4.6 хувиар буурсан, **10** гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь 2-оор буюу 20 хувиар өссөн, **16** гомдол, мэдээлэлд мөрдөн шалгах хэрэг /ЭХТА-ийн 10.4.1/ нээсэн нь ижил төвшинд, **18** гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал хүргүүлсэн нь 50 хувь өссөн бөгөөд 2 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, одоо 7 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл бүрийг бүртгэж, нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэх, хуулийн анхны хугацаанд шуурхай шалгаж шийдвэрлэх, хариу өгөх ажилд хэсгийн даргаас тогтмол хяналт тавьж, 7 хоногийн Даваа, Баасан гаригт өргөдөл, гомдлын тулгалт хийж ажилласан.

Мөрдөн байцаалтын өмнөх оны үлдэгдэл 1 хэрэг дээр гомдол, мэдээллээс шууд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 40, мөрдөн шалгах хэрэг нээсэн 17, харьяаллаар хүлээн авсан мөрдөн шалгах хэрэг үгүй, хэрэг бүртгэлтийн хэргээс 44 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж нийт **101** хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үеэс 15 хэргээр буюу **12.1** хувиар буурсан байна. Нийт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан **101** хэргээс 67 холбогдогчтой **97** хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оны шийдвэрлэлтийн харьцуулалт адил төвшинд байна, үүнээс хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай **72** хэрэг, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй яллагдагчтай мөрдөн байцаалтын 1, ЭХТА-ийн 10.4.1-ээр /Бусдыг амиа хорлоход хүргэх/ мөрдөн шалгах хэрэг нээсэн 17 хэргийг хэрэгсэхгүй болгох санал хүргүүлж, харьяаллын дагуу 3 хэрэг шилжүүлж, **5** хэргийг нэгтгэн шалгаж шийдвэрлэжээ. Одоо мөрдөн байцаалтын үлдэгдэл **4** хэрэгтэй байна. Мөрдөн байцаалтын 101 хэргээс 100 хэргийг хуулийн анхны хугацаанд нь шийдвэрлэж 1 хэрэгт мөрдөн байцаалтын хугацаа сунган шалгаж байна.

Хэрэг бүртгэлтийн өмнөх оны үлдэгдэл 10 хэрэг дээр, шинээр 6 хэрэг нээж, зөрчлөөс болон бусад албадаас харьяаллаар 48 хэрэг хүлээн авч, прокуророос 1 хэргийг сэргээн, нийт **64** хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үеэс 10 хэргээр өссөн бөгөөд нийт шалгасан хэрэг бүртгэлтийн 64 хэргээс 57 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс хэрэг бүртгэлтийн **44** хэрэгт эрүүгийн үүсгэж яллагдагчаар татаж, хэрэг бүртгэлтийн ажиллагааг хаах саналтай 13 хэргийг хүргүүлж шийдвэрлэн одоо **7** хэрэгт бүртгэлтийн хэрэгт шалгах ажиллагаа явуулж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан 52.210.798 төгрөгийн хохирлоос мөрдөн шалгах ажиллагааны явцад 47.202.530 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 2.550.000 төгрөгийн эд хөрөнгө битүүмжлэн ажилласан бөгөөд хохирол нөхөн төлүүлэлт 90.3 хувьтай хүрэх түвшинг хангасан байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл, зорилгоор иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөгчийн мэдэгдэл 72 бичиж холбогдох хүн, хуулийн этгээдэд хүргүүлэн 61 хариуг хуулийн хугацаанд авч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа мэдээлэл хийж, 4 удаа 217

хүнд хууль сурталчлан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор холбогдлын талаар яриа таниулга хийж, ЦЕГ болон бусад холбогдох албадаас зохион байгуулсан урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээлэл цахим орчинд түгээх 2 удаагийн аянд 4 алба хаагч 54 мэдээллийг давхардсан тоогоор 451 группт 8765 удаа түгээсэн.

Тайлангийн хугацаанд Улаанбаатар хотын Цагдаагийн газрын харьяа дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүд, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу “Харьяаллын бус газарт ажиллагаа явуулахаар даалгасан мөрдөгчийн даалгавар” 17, Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэрэгт прокурорын тогтоол 2 хүлээн авч 26 хүнийг хохирогч, хууль ёсны төлөөлөгчөөр, 34 хүнийг гэрчээр байцаан, хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Шүүхийн шийдвэр биелүүлэх нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа 18 яллагдагчаас зохих зөвшөөрлийн дагуу гэрч, яллагдагчаар мэдүүлэг авч, байгууллага аж ахуйн нэгжээс холбогдох 41 лавлагааг авч, шүүх, прокурорын байгууллагаас 22 холбогдогчийн таслан шийтгэх тогтоолын хуулбарыг албажуулан авч хариуг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Гэмт хэрэгт шалгагдаж байгаа эсэх талаар 22 албан бичгийн хариуг хугацаанд нь нийслэл, аймаг дахь Цагдаагийн газар, хэлтэс нэгжид хүргүүлсэн. Мөрдөгч нараас Улаанбаатар хотын харьяа дүүрэг, бусад аймаг, сумдын Цагдаагийн газар, хэлтсүүдэд мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус газарт явуулах 39 даалгавар хүргүүлж биелэлтийг тооцон, 6 удаагийн албан томилолтоор Улаанбаатар хот, орон нутаг, харьяа сумуудад ажилласан байна.

Мөн хугацаанд Цагдаагийн байгууллагын Эрэн сурвалжлалтын АСАП санд гэмт хэрэгт сэрдэгдэж эрэн сурвалжлагдаж байсан сэрдэгдсэн 2 хүний эрэн сурвалжлалтыг зогсоож, 8 хэргийг нөхөн илрүүлж ажилласан.

**4.2. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:** Гүйцэтгэх ажлын шугамаар 100 мэдээлэл авч баримтжуулан шалгаж шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд заасан Мөрдөн шалгах нууц ажиллагааг тус хэлтсийн гүйцэтгэх ажлын эрх бүхий алба хаагч нараас 3 зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйл, мал амьтны 13, хүний 14, нийт 27 мэдээллийг эрэн сурвалжлах Асап санд шивж оруулан шийдвэрлэлтийг нь хийсэн.

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулан эд зүйл, 9, мал, амьтан 7, тээврийн хэрэгсэл 2, оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 15, бусад хүний 5 нийт 39 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож эрэн сурвалжлалтыг хааж төвлөрсөн тоо бүртгэлд оруулсан.

Гэмт хэргийн шинжтэй 82 гомдол мэдээлэл хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулж 19 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, 26 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 5 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн, 28 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай шилжүүлэн шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нараас 162 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж 16 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлэн, 15 хэргийг хааж, 7 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэн 124 хэргийн үлдэгдэлтэй байна.

Зөрчил шалгаж шийдвэрлэх 7 алба хаагчаас нийт 246 зөрчил илрүүлж 155 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 91 зөрчилд зөрчлийн хэрэг нээж зөрчлийн хэргийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 183 хүнийг 21,445,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан байна.

Цагдаагийн хэлтсийн болон харьяа тойргийн сумдын алба хаагч нараас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 307.5.2 дох хэсэгт зааснаар

нийт 8 алба хаагч 14 илтгэх хуудас бичиж гүйцэтгэх ажлын эрх бүхий алба хаагч нар шалгаж нийт 12 илтгэх хуудас батлагдаж 1 илтгэх хуудас батлагдаагүй, 1 илтгэх хуудас шалгагдаж байна.

**4.3. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өдөр, оройн эргүүлд нийт 322 удаа 1932 цаг, Цагдаагийн газар болон цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Өргөтгөсөн эргүүл”-д нийт 15 удаа 120 цагийн үүрэг тус тус гүйцэтгэж хэв журмын алба хаагчид нийт 1598 зөрчил илрүүлж 1433 иргэнд 32,868,500 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 164 зөрчил, хэв журам 168 зөрчил илрүүлж ажилласан.

Урьд оны мөн үетэй харьцуулахад нийт зөрчил 211 зөрчлөөр буурч, мөнгөн дүн 12,866,500 төгрөгөөр өссөн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 106 зөрчлөөр буурсан. Хэв журмын зөрчил 32 буурсан үзүүлэлттэй байна.

Код 307 илтгэх хуудас 2, эрэн сурвалжилж олж тогтоосон 3 хүн байна.

**4.4. Замын цагдаагийн албаны чиглэлээр:** Сумдын алба хаагчид согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 159 зөрчил илрүүлж, зөрчилтэй явсан 8922 жолоочид 169,305,518 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар давхардсан тоогоор 20560 тээврийн хэрэгсэл шалгаж 8922 зөрчил илрүүлж ажилласан байна.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 159 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1-д заасны дагуу 1 жилээр хасаж 63,600,000 төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 175 жолоочийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 98 хүнд 20.200.000 төгрөгийн торгууль, бусад зөрчил гаргасан 8922 жолоочийг 169.305.518 төгрөгөөр торгож ажилласан.

Цагдаагийн хэлтсийн жижүүрийн 102 дугаарын утсанд иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 10 гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-202-ийн дагуу хүлээн авснаас ослын газрын үзлэг хэмжилт хийж 4 гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэн Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 51 дэх заалтаар арга хэмжээ тооцон ажилласан.

#### **4.5 Шуурхай удирдлагын чиглэлээр:**

Жижүүрийн мөрдөгч нар томилгоот жижүүрт 165 удаа 3960 цагийн үүрэг гүйцэтгэж зөрчлийн шинжтэй 459 гомдол мэдээллийг хуулийн хүрээнд шалгаж шийдвэрлэх ажиллагаа явуулан 438 гомдол мэдээлэлд зөрчлийн хэргийн дугаар авч зөрчил гаргасан 175 иргэнийг сум дундын шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж албадан сургалтад хамруулж ажилласан. Олон нийтийн газар ил задгай бие зассан, шүлс, нус цэрээ хаясан, хориглосон газарт архидан согтуурсан, гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэсэн зэрэг 133 зөрчил хялбаршуулсан журмаар материал бүрдүүлж 133 иргэнийг 5.699.000 төгрөгөөр торгож, харьяаллын дагуу эзэн холбогдогчийн олж тогтоон зөрчлийн хэрэг 7, гомдол мэдээлэл 2 мөрдөн байцаах хэсэгт шилжүүлэн ажилласан.

Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа нар томилгоот жижүүрт 165 удаа 3960 цагийн үүрэг гүйцэтгэж давхардсан тоогоор 135 аж ахуйн нэгж байгууллага, 1568 тээврийн хэрэгсэл, 206 хүн шалгаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 11, хэв журмын 28 зөрчил илрүүлсэн.

**Мэдээлэл судалгааны чиглэлээр:** Гэмт хэргийн маягтууд 310, зөрчлийн маягтууд 815, гомдлын 1101 маягтууд 831 маягт, мэдээллийн санд оруулж, албан хаагчдаас оруулсан маягтыг төвлөрсөн тоо бүртгэлд авч ажилласан байна. Эрх

бүхий албан хаагчдаас санд оруулсан маягтуудаас мэдээлэл судалгааны мэргэжилтнээс 81 мэдээллийн сантай холбоотой зөрчлийг холбогдох албан хаагчдаар засуулж зөвтгөсөн байна. Гомдлын төрөл засуулахаар 15 маягт буцааж засварлаж зөвтгөсөн.

Гэмт хэрэг, зөрчлийн санд ажиллах чиглэлээр сумдын албан хаагчдад сургалт 4 удаа зохион байгуулан ажилласан. Зөрчил гаргасан алба хаагчдаас дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа бичүүлж авсан.

Зөрчлийн удаашралтай байгаа 56 зөрчлийн хэргийн судалгаа гарган удирдлагад танилцуулан хэргийн шийдвэрлүүлэн санд шивүүлж ажилласан.

**4.6 Санхүү аж ахуйн чиглэлээр:** Тус цагдаагийн хэлтэс нь 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу улсын төсвөөс 412,340,800 төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авсан байна.

Үүнээс алба хаагч нарын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 345,749,570.75 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 7,670,100 төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал болох гэрэл цахилгааны зардалд 3,784,700 төгрөг, түлш халаалтын зардалд 10,235,497.59 төгрөг, цэвэр бохир усны зардалд 826,200 төгрөг, хангамжийн материалын зардал болох бичиг хэргийн зардалд 870,500 төгрөг, тээвэр шатахууны зардалд 15,591,610 төгрөг, шуудан харилцаа холбоо интернетийн төлбөрт 712,790 төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 253,750 төгрөг, норматив зардал болох эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 45,000 төгрөг, хоол хүнсний зардалд 1,309,000 төгрөг, эд хогшил урсгал засварын зардалтай холбоотой урсгал засварын зардалд 1,764,900 төгрөг, томилолт зочид төлөөлөгчдийн зардал болох дотоод албан томилолтын зардалд 708,000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал болох хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 200,000 төгрөгийг тус тус зарцуулж батлагдсан төсвийг 94.5 хувийн гүйцэтгэлтэй, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор улсын төсөвт 1,880,300 төгрөгөөр төвлөрүүлэхээр батлагдсанаас 1,994,850 төгрөгийг төвлөрүүлэн 106 хувийн гүйцэтгэлтэй байна.

2023 оны 03 дугаар сарын байдлаар зөрчил гаргасан иргэдийг нийт 182 ш шийтгэлийн хуудсаар торгож, нийтдээ 40,335,000 төгрөгийг орон нутгийн санд төвлөрүүлэн ажилласан байна.

2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар эрүүлжүүлэх, баривчлах байрны орлого 1,844,850 төгрөг байна.

Алба хаагч нарын 2023 оны 01-03 дугаар сарын нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд нь гаргаж нийгмийн даатгалын нэгдсэн n.daatgal.mn цахим хуудсанд шивж оруулан, цахим тайлан илгээн ажиллалаа.

2023 онд ажлаас халагдаж, чөлөөлөгдсөн 2 алба хаагчийн тооцоо үүссэнээс Х.Найдандорж 310,291 төгрөгийн тооцоог барагдуулсан ба А.Үйтүмэнгийн 281,446 төгрөгийн тооцоог барагдуулахаар ажиллаж байна.

#### **Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд:**

**“Сар шинэ 2023”** нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчид орон нутгийн А-0601, А-0301 дугаартай авто замуудад хяналт шалгалт хийж нийт 3400 тээврийн хэрэгсэл шалгаж зурагт хуудас бүхий 2 төрлийн 1200 ширхэг санамж сэрэмжлүүлэг бэлтгэж иргэд жолооч нарт тарааж, согтуугаар тээврийн 50-н зөрчил илрүүлж, зөрчилтэй явсан 3522 жолоочид 74.320.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Өвөрхангай аймгийн Хэмжээнд зохион байгуулсан **“Зочид буудал”** хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Хархорин суманд үйл ажиллагаа явуулдаг 6 буудал, Бат-Өлзий суманд үйл ажиллагаа явуулдаг 2 буудалд хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр 1 албан мэдэгдэл бичиж хүргүүлсэн.

Мөрдөн байцаах хэсгээс ЦЕГ-ын Тэргүүн дэд даргаас ирүүлж МБА-наас зохион байгуулсан “Хэргийн Илрүүлэлт-Шийдвэрлэлт 1” арга хэмжээний хүрээнд Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх 1 сарын хугацаатай арга хэмжээний графикт 2 хэргийг тусгуулж, шийдвэрлэх хэргийн графикт мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа 8 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан 5 хэргийг шүүхэд шилжүүлж, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй яллагдагчтай 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг хааж шийдвэрлэн ажилласан.

“Хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж Хархорин суманд архи согтууруулах ундаагаар үйл ажиллагаа явуул буй аж ахуй нэгж, цэгүүдийн нийт 46, архи согтууруулах ундаагаар худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, хүнсний дэлгүүр, ажиллагаа явуулдгаас 35 дэлгүүр, 11 баар зоогийн газрын тусгай зөвшөөрлийг шалгаж тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан “Гурван тамир” хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундааны зүйлийг түр хураан авч Зөрчлийн тухай хуулийн 6.5.11 заалтаар 500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

“Төгсөлт” тусгай арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 4 сургуулийн ахлах ангийн нийт 622 сурагчдад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, сургуулийн орчинд тэдэнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах зорилгоор “Согтууруулах ундаа, утаат болон электрон тамхины хор уршиг”, Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах”, сэдэвт яриа таниулга хийж эцэг эхчүүдийн төлөөлөлд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулав. 2022-2023 оны хичээлийн “Эрдмийн баяр” болохтой холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээг зохион байгуулах 9 заалт бүхий шаардлага хүргүүлэв.

Тээврийн цагдаагийн алба Өвөрхангай аймгийн цагдаагийн газраас зохион байгуулсан **“Сургууль орчмын бүс”, “Хамгаалах бүс”, “Хүүхдийн аюулгүй тээвэр”, “Мотоцикл”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал”, “Тэмдэг, тэмдэглэл, техник хэрэгслийн үзлэг тооллого”, “Уусан бол бүү жолоод”** нөлөөллийн аяны хүрээнд Хархорин сум болон тойргийн сумдын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэд олон нийтэд 110 төрлийн санамж, сэрэмжлүүлэг тарааж түүний хор уршгийг иргэд олон нийтэд таниулах видео, контент, подкаст, шторк нийт 35600 иргэнд түгээж ажилласан.

Зам тээврийн осол, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр 12 албан мэдэгдэл бичсэн.

“Мотоцикл ба хамгаалах малгай” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мотоциклийн “А” ангиллын эрхийн үнэмлэхтэй жолооч нарын дунд “Уран жолоодлогын” тэмцээн зохион байгуулж нийт 2500 ширхэг 4 төрлийн санамж сэрэмжлүүлгийг 1500 мотоциклийн жолоочид түгээж хөдөлгөөнд оролцохдоо хамгаалах малгай тогтмол хэрэглэх талаар мэдээлэл хийсэн.

### **НАЙМ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

1. Цагдаагийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах,
2. Алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулан, техник хэрэгслийг шинэчлэх,
3. Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагаар 100 хувь барьж дуусган хүлээн авах,
4. Сум орон нутгийн дэмжлэгтэйгээр дулааны улиралд унах бүх сумдыг мотоциклоор хангах ажлыг зохион байгуулах,

5. Цагдаагийн газрын “Сургалт дадлагын төв”-ийг өргөжүүлэх, бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг хийх, алба хаагч нарын мэдлэг ур, чадварыг дээшлүүлэх чиглэлээр бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулах,

6. Аймгийн хэмжээнд “Камержуулалт” аяныг жил бүр зохион байгуулан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах, байршуулж байгаа камерын чанар, үзүүлэлтийг сайжруулан ажиллах,

7. Алба хаагч нарт ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслээр сум орон нутгийн дэмжлэгийг авч шийдвэрлүүлэх,

8. “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай 2” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

9. Төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох,

10. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд дэвшүүлсэн зорилтыг ханган ажиллах.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР